



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

# ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР

---

2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот

2025 он

## АГУУЛГА

<b>УДИРТГАЛ</b> .....	<b>2</b>
<b>НЭГ.ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ</b> .....	<b>4</b>
<b>ХОЁР.ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ</b> .....	<b>13</b>
2.1.Нийслэлийн Засаг даргын захирамж, зөвлөлийн хурлын тэмдэглэл, шуурхай хуралдаанаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулах хүрээд:.....	13
2.2.Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурал, хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилт: ...	17
2.3.Нийслэлийн удирдлага, газрын удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт: .....	17
2.4.Нийслэлийн Засаг даргаас Засгийн газрын гишүүд, салбарын сайд нартай байгуулсан хамтран ажиллах гэрээнд заасан зорилтуудын хэрэгжилт, үр дүн, тайлагнасан байдал...	19
2.5.Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх чиглэлээр хийсэн ажил, үр дүн .....	20
<b>ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b> .....	<b>21</b>
3.1. Байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүргийн хэрэгжилт .....	21
3.1.1. Барилга, дэд бүтцийн салбарын төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх: .....	21
3.1.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг зохион байгуулах.....	45
3.2. Газрын үндсэн чиг үүрэгтэй холбогдох хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, үр дүн .....	47
3.3. Үндсэн чиг үүргийн хүрээнд нийслэлийн удирдлагад хууль, эрх зүйн дэмжлэг үзүүлэх, хууль, шүүхийн өмнө төлөөлөх .....	48
3.4. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн.....	48
3.5. Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө болон нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт, төсвийн гүйцэтгэл.....	49
3.6. Төрийн захиргааны албан хаагчдын ажлын гүйцэтгэл, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэсэн байдал.....	50
3.7. Хяналт шалгалтын байгууллагаас ирүүлсэн санал зөвлөмж, түүнийг хэрэгжүүлсэн байдал .....	50
3.8. Үндсэн чиг үүргийн биелэлт, үр дүнд хийсэн дотоод аудит, хяналт шалгалт, дүгнэлт	51
3.9.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт .....	52
3.10. Архив, албан хэрэг хөтлөлт, хариутай болон хариугүй албан бичгийн шийдвэрлэлтийн байдал .....	64
3.11. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт .....	73
3.12. Ажилтан, албан хаагчдын ажлын сахилга хариуцлага, байгууллагын соёл, дэг журмыг сахиулах, ажлын бүтээмжийг дээшлүүлсэн байдал, үр дүн .....	75
3.13. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ .....	76
<b>ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ</b> .....	<b>77</b>
4.1. Байгууллагын ил тод байдлыг хангах чиглэлээр хийж хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн .....	77
4.2.Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангасан байдал буюу шилэн дансны хөтлөлтийн байдал, үр дүн.....	80
<b>ТАВ. БУСАД МЭДЭЭЛЭЛ</b> .....	<b>81</b>
5.1. Олон нийтийн арга хэмжээ.....	81
5.2. Оны онцлох үйл явдлууд.....	83
<b>ЗУРГАА. ДҮГНЭЛТ</b> .....	<b>87</b>
<b>ДОЛОО. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, САНАЛ</b> Error! Bookmark not defined.	

## НИЙСЛЭЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 15

Улаанбаатар хот

### УДИРТГАЛ

Нийслэлийн Хяналт шалгалтын газар нь Монгол Улсын хууль, тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, нийгэм эдийн засгийн зорилтууд, Нийслэлийн хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлого, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргаас хот байгуулалт, барилга, дэд бүтцийн салбар дахь төрийн хяналт шалгалтын талаар баримтлах бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах үндсэн чиг үүрэг бүхий Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг юм.

### БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

**Алсын хараа:** Олон улсын жишигт нийцсэн үндэсний стандартыг хэрэгжүүлж, шударга хяналтыг эрхэмлэсэн байгууллага болно.

**Эрхэм зорилго:** Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад барилга, дэд бүтцийн бүтээн байгуулалтад стандарт, нормыг мөрдүүлж, төрийн хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлнэ.

**Үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг:** Барилга, хот байгуулалт, дэд бүтэц, газрын харилцаа, уг салбарт орчны аюулгүй байдлыг хангуулах хүрээнд төрийн хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлж, иргэн, хуулийн этгээдээс гаргасан өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, холбогдох хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт, техникийн зохицуулалт, үндэсний болон хотын стандартын хэрэгжилтэд хяналт тавина.

Газрын дүрмийг Нийслэлийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн А/654 дүгээр захирамжаар шинэчлэн батлуулж, дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- барилга, хот байгуулалт, дэд бүтцийн салбарын төрийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх;
- хууль тогтоомж, стандарт, норм, дүрмийг мөрдүүлэхэд төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг мэдээлэл, сургалт, арга зүйгээр хангах, зөвлөн туслах, сурталчлан таниулах;
- барилга, дэд бүтцийн салбарын хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн баримт бичиг, үндэсний болон хотын стандарт, норм дүрмийн хэрэгжилтийн байдлыг судалж, эрсдэлийн үнэлгээ хийх;
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Хяналт шалгалт хийх нийтлэг журмын дагуу төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион байгуулж, түүний үр дүнд илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг авах;
- нийслэлийн хэмжээнд баригдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах чиг үүргийг хэрэгжүүлэх;
- барилга байгууламж, их засвар тохижилтын ажлыг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах;
- барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлтийг баталгаажуулах;
- ашиглалтад орсон барилга байгууламжийн талаарх мэдээллийг нэгтгэн, холбогдох мэдээллийн санг баяжуулах.


**Газрын бүтэц, орон тоо:** Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн “Хяналт шалгалтын газрын бүтэц орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай” А/596 дугаар захирамжаар тус газар нь 6 нэгж, 98 хүртэлх орон тоог баталснаас 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 67 албан хаагчдын бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Схем. Газрын бүтэц, зохион байгуулалт




Одоо ажиллаж буй орон тооны мэдээлэл:

Д/д	Хэлтэс	Батлагдсан орон тоо	Үүнээс
1	Газрын дарга	1	1
2	Захиргаа, санхүүгийн хэлтэс	21	16
3	Дотоод хяналт, шинжилгээний хэлтэс	5	4
4	Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтэс	12	9
5	Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс	28	17
6	Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтэс	23	14
7	Орчны аюулгүй байдлын хяналтын хэлтэс	8	6
<i>Нийт:</i>		<b>98</b>	<b>67 (56.1%)</b>



- Удирдах-6
- Төрийн захиргаа-43 (Улсын байцаагч-27)
- Төрийн үйлчилгээ-24



## НЭГ.ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ

Улс, нийслэлийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээг “Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-д тусган хэрэгжүүлж, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”-ын дагуу хяналт шинжилгээ, үнэлгээ хийн улирал, хагас тутам хэрэгжилтийг нэгтгэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тайлагнан ажиллаж байна.

Хүснэгт. Зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээний тоо

Д/д	Бодлогын баримт бичгийн нэр	Арга хэмжээ
1	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	2
2	Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	11
3	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	3
4	Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө	2
<b>Нийт:</b>		<b>17</b>

Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, холбогдох журамд заасан хугацаанд Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт дараах байдлаар тайлагнаж ажиллав. Үүнд:

- “Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-нд байгууллагын хариуцах 2 зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг нэгтгэж, 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдөр НЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлсэн.
- “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан 1 арга хэмжээний 2025 оны хагас жилийн биелэлтийг 06 дугаар сарын 02-ны өдөр НЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлсэн.
- “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” болон “Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний эхний хагас жилийн хэрэгжилтийг өссөн дүнгээр нэгтгэж, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүгнэлтийн хамт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 01/612 дугаар албан бичгээр НЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлсэн.
- “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг 2025 оны наймдугаар сарын байдлаар нэгтгэн, нотлох баримтын хамт 2025 оны 08 дугаар сарын 14-ний өдөр 01/768 дугаартай албан бичгээр НЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлсэн.
- “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 2025 оны хэрэгжилтийг 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 01/1192 дугаартай албан бичгээр НЗДТГ-ын Нийслэлийн Бодлого, төлөвлөлтийн газарт хүргүүлсэн.
- “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” болон “Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний жилийн эцсийн хэрэгжилтийг 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 01/1193 дугаартай албан бичгээр НЗДТГ-ын Дэд бүтэц, хөгжлийн бодлогын хэлтэст хүргүүлсэн.
- “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 2025 оны хэрэгжилтийг 2025 оны


12 дугаар сарын 02-ны өдрийн 01/1194 дугаартай албан бичгээр НЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлсэн.

Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг дараах байдлаар хураангуйлав.

➤ **Орон сууцны хотхон, хорооллын орц, гарц хаагдсан хэсгийн зөрчлийг арилгаж, хариуцлага тооцох хүрээнд:** (НЗДҮАХ 1.2.22)

Орон сууцны хотхон, хорооллын орц, гарц хаагдсан зөрчлийг арилгах ажлын хүрээнд нийт 25 байршилд хяналт шалгалт хийж, 13 байршилд орц, гарц хаагдсан зөрчлийг арилгуулж, бусад байршлуудад зөрчлийг арилгуулах талаар холбогдох байгууллагуудад мэдэгдэл, шаардлага хүргүүлэв. Үүнд:

- Нийслэлийн Засаг даргын А/237 дугаар захирамжийн хүрээнд орон сууцны хотхон, хорооллын орц, гарц хаагдсан зөрчлийг арилгах хяналт шалгалтыг зохион байгуулж, Баянгол, Баянзүрх, Сүхбаатар дүүргүүдэд зөвшөөрөлгүй орц, гарц хаасан 4 зөрчлийг илрүүлэн Нийслэлийн газар зохион байгуулалтын албанд шилжүүлэв.
- Хан-Уул дүүргийн 21 дүгээр хороо “Эвэл Апартамент” хотхон, Баянзүрх дүүргийн 26 дугаар хороо “Мандала” орон сууцны хотхонд авто зогсоолын орц, гарцын норм, стандартын хэрэгжилтийг хангуулав.
- Баянгол дүүргийн ерөнхий боловсролын 73, 184 дүгээр сургуулийн орц, гарц хаагдсан асуудалд хяналт шалгалтыг хийж, зөрчлийг арилгах талаар Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, Нийслэлийн Замын хөгжлийн газар, Нийслэлийн Онцгой байдлын газарт мэдэгдэв.
- Баянгол дүүрэг, 9 дүгээр хороо, Билгүүн бар ХХК-ийн хэрэгжүүлж буй төслийн ажилд шалгалт хийж, гадна тохижилт, авто зам, орц, гарцын асуудлыг шийдвэрлэх албан шаардлага хүргүүлэв.
- Хан-Уул дүүргийн 3 дугаар хороо, “Магнет Импорт” барилгын материалын хуурай хольцын үйлдвэрийн үйл ажиллагааг төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар зогсоож, суурьшлын бүсээс нүүлгэн орц, гарцыг чөлөөлсөн.
- Хан-Уул дүүргийн 22 дугаар хороо, Сарнайх дэлгүүр, Спарк цэцэрлэгийн барилгын явган хүний зам, замын гарцыг хаасан зөрчлийг арилгуулсан.
- Төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар хотхон, хорооллын орц, гарц хаасан 15 байршилд хяналт хийж, “Орц гарцыг нээх тухай” 24 заалт бүхий 8 албан шаардлага хүргүүлж, хэрэгжилтийг хангуулсан бөгөөд 7 байршилд албан бичгээр мэдэгдэл хүргүүлж шийдвэрлэсэн.



➤ **Төвийн бохир усны шугам болон урьдчилсан цэвэрлэх байгууламжид бохир усаа нийлүүлж буй бохирдуулагч үйлдвэрүүдэд хяналт шалгалт хийж, зөрчлийг арилгуулах хүрээнд:** (МУЗГҮАХ-2.4.3.7, НЗДҮАХ-1.3.21)

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2025 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн А/68 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг батлагдсан удирдамжийн хүрээнд төвийн бохир усны шугам болон урьдчилсан цэвэрлэх байгууламжид бохир усаа нийлүүлж буй үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд хяналт шалгалт хийв. Шалгалтаар Баянгол, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй арьс шир боловсруулах, ноос ноолуур угаах, боловсруулах, өлөн боловсруулах, мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, талх, чихэр, архи, ундааны үйлдвэрүүдийн хаягдал бохир усны бохирдлын түвшин, урьдчилсан цэвэрлэх байгууламж суурилуулсан байдалд үнэлгээ хийсэн. Уг хяналт шалгалтад нийт 49 иргэн, аж ахуйн нэгжийн үйлдвэр хамрагдсан бөгөөд эдгээрээс урьдчилсан цэвэрлэх байгууламж суурилуулаагүй, хаягдал бохир усны чанар нь стандартын шаардлага хангахгүй зэрэг зөрчил илэрсэн.





Шалгалтаар илэрсэн зөрчлийн хүрээнд урьдчилан цэвэрлээгүй хаягдал усыг төвлөрсөн шугам сүлжээнд нийлүүлсэн 6 аж ахуйн нэгж, байгууллагад Зөрчлийн тухай хуулийн дагуу 12 сая төгрөгийн торгууль ногдуулж, ЭБАТ-ны даалгавар хүргүүлэв. Мөн зөрчил, дутагдал илэрсэн 10 аж ахуйн нэгжид холбогдох зөрчлийг арилгах тухай албан шаардлага хүргүүлж, хугацаатай үүрэг даалгавар өгч ажиллав.

➤ **Ашиглагдаж буй барилга байгууламжийн хөрсний усны нэвчилтийн байдалд хяналт шалгалт хийж эрсдэлийг бууруулах хүрээнд: (НЗДҮАХ 1.3.12)**

Нийслэлийн Хяналт шалгалтын газар, Хот байгуулалт, Хотын стандартын газар, Геодези усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ-аас гаргасан судалгаагаар гаргасан нийслэлийн төвийн зургаан дүүргүүдэд байрладаг хотхон хорооллуудын хур борооны ус ихээр тогтдогт нийт 38 байршилд Нийслэлийн Хяналт шалгалтын газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 02-13-04/023/25 дугаартай удирдамжийн дагуу хяналт шалгалт хийж, 8 байршилд зөрчлийг арилгуулав.

Шалгалтын танилцуулга, цаашид авах арга хэмжээний саналыг 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 01/1045 тоот албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Улаанбаатар Захирагчийн ажлын алба, Хот байгуулалт, Хотын стандартын газар, Геодези усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ-т тус тус хүргүүлэв.

Хур борооны ус ихээр тогтдог байршлуудад хийсэн хяналт шалгалт



➤ Нийслэлийн хэмжээнд шинээр хийгдэж буй авто зам, замын байгууламжийн төсөл, арга хэмжээнд төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулах хүрээнд: (НЗДҮАХ-1.3.11)





Зам, тээврийн хөгжлийн яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2025 оны “Урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай” 04/05 дугаар удирдамжийн хүрээнд дараах төслүүдэд хяналт шалгалт хийв. Үүнд:

- Дүүжин тээврийн төслийн барилга угсралтын ажилд шалгалт хийж, барилгын түр хашаа, орчны аюулгүй байдлыг хангуулах, дутагдлыг арилгуулах талаар гүйцэтгэгч Моннис инженеринг ХХК-д албан шаардлага хүргүүлэв.
- Сонгинохайрхан дүүргийн Соёлын төвийн урд хэсгийн авто замын угсралтын ажлыг шалгаж, батлагдсан зураг төсөл зөрчиж авто замын зорчих хэсгийн цахилгааны тулгуур шилжүүлэхгүйгээр асфальтбетон хучилт хийсэн “Баян-Өлзийт зам” ХХК-д Зөрчлийн тухай хуулийн дагуу торгуулийн арга хэмжээ авч, зөрчил арилгах албан даалгавар хүргүүлэв.
- Баянзүрх дүүрэг Сансарын үйлчилгээний төв орчмын тохижилтын ажлыг шалгаж, илэрсэн дутагдлыг арилгуулахаар гүйцэтгэгч “Морин сувд” ХХК-д албан шаардлага хүргүүлэв.
- Сонгинохайрхан дүүрэг, 27 дугаар хороо, 46 байрны ард авто машины зогсоол шинээр байгуулах ажлын гүйцэтгэлд хяналт шалгалт хийв.
- Баянгол дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Эрчим хүчний гудамжны авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажлын зураг төсөл, холбогдох баримт бичиг, барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг шалгаж, зөвлөмж өгөв.

➤ Барилга, байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийн төлөвлөлтийн байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, тэгш хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд: (НЗДҮАХ 2.3.2, НХТЖҮЧ-9.5.1)

Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яамны Салбарын ерөнхий байцаагчийн 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 02-00/06 дугаартай удирдамжийн дагуу орон сууц, олон нийтийн 450, сургууль цэцэрлэгийн 160, нийт 610 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, шаардлагыг хангах зорилгоор барилга байгууламжийн зураг төсөл, угсралт, ашиглалтын чанар, аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгууллаа.

Шалгалтын үр дүнд Барилгын техникийн хяналтын улсын байцаагчийн 02-13-01/033/48 дугаартай “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн барилга байгууламжид тавигдах шаардлага, аюулгүй байдлыг хангуулах тухай” зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллах үүрэг чиглэл өгөв.



➤ Төрийн хяналт шалгалтын давхардлыг арилгах, хараат бус, үр дүнтэй хяналтын тогтолцоог бүрдүүлж, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд: (НЗДҮАХ 5.1.7)

Төрийн хяналт шалгалтын эрх зүйн орчныг ижил түвшний эрх зүйн тогтолцоо бүхий улс орны хяналтын тогтолцооны судалгаа хийх: Төрийн хяналт шалгалтын эрх зүйн орчныг бусад ижил түвшний эрх зүйн тогтолцоо бүхий улс орнуудын хяналтын тогтолцоотой харьцуулсан судалгаа хийх ажлын хүрээнд Герман, Япон, Швейцарь, Сингапур, Өмнөд Солонгос, Норвеги, Австрали, Бүгд Найрамдах Хорват зэрэг ул орнуудын барилгын хяналтын тогтолцоог ерөнхий чиглэлээр судлав. Тус судалгааны хүрээнд Монгол Улсын төрийн хяналт шалгалтын эрх орчныг Ром-Германы эрх зүйн бүл бүхий дараах улс орны эрх зүйн орчинтой харьцуулсан судалгааг хийсэн. Үүнд:

- Бүгд Найрамдах Солонгос Улсын төрийн хяналт, барилгын хяналтын тогтолцоо, эрх зүйн орчин-Аудит болон хяналт шалгалтын тухай хууль (Board of Audit and Inspection Act), Барилгын хууль (Building act)
- Бүгд Найрамдах Словень улсын төрийн хяналт шалгалтын тогтолцоо, эрх зүйн орчин- Хяналт шалгалтын тухай хууль (Inspection act of Slovenia)

Арга хэмжээ: 610  
ЗДҮАХ-т тусгагдсан зорилт: 5.1.7.Төрийн хяналт шалгалтын давхардлыг арилгах, хараат бус, үр дүнтэй хяналтын тогтолцоог бүрдүүлж, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

**СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ**

Монгол Улсын төрийн хяналт шалгалтын эрх орчныг Ром-Германы эрх зүйн бүл бүхий дараах хөгжингүй улс орны эрх зүйн орчинтой харьцуулсан судалгааг хийсэн. Үүнд:

**ДҮГНЭЛТ**

"Монгол Улсад хяналтын нэгдмэл тогтолцоо илүү тохирох тул Төрийн хяналт шалгалтын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж (2021 онд Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс хийгдэж байсан), хяналт шалгалт, арга хэлбэрийг цэгцлэн тодорхойлж, хяналт шалгалтыг хэрэгжүүлэх үндэслэл, нийтлэг журмыг илүү боловсронгуй, ойлгомжтой болгон хуульчлах зайлшгүй шаардлагатай байна.

Захиргааны ерөнхий хууль, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Прокурорын тухай болон бусад хяналт тавьдаг, хэрэгжүүлдэг салбар хуулиуд шинээр болон шинэчлэгдэн батлагдсан учир Төрийн хяналт шалгалтын тухай хуулийг эдгээр хуульд нийцүүлэн хяналтын байцаагчийн бүрэн эрх, хяналт шалгалтыг үр дүнтэй явуулах эрх зүйн боломжийг өргөжүүлэн хуульчлах шаардлагатай" гэж нэгдсэн дүгнэлтэд хүрсэн.

Хяналт шалгалтын үр дүн, үр нөлөөг сайжруулах хүрээнд хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэх саналыг боловсруулж, уламжлах: Нийслэлийн Засаг даргын 2024 оны 12 сарын 04-ний өдрийн А/1459 дүгээр захирамжаар хяналт шалгалтын эрх зүйн орчныг сайжруулах санал зөвлөмж боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хэсгийн хүрээнд Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Барилгын тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Хяналтын улсын байцаагчийн эрх олгох, цуцлах журам зэрэг нийт 6 хууль тогтоомжийн 24 зүйл, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, танилцуулгын хамт 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 01/186 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ТҮРГИЙН ТУС ОРЧНЫГ ГҮЙЦЭТГЭГЧ ДАМГАЛАН ТАНАА**

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР

Навсэндэн зам 1200, Ардатын ам, 23 дугаар хороо, Хөвсгөл дүүрэг, Улаанбаатар хот, Т-1100  
Утас: 0976 7011 8030, 7011 6940  
Цахим хуудас: www.standart.mn.gov.mn

2025.02.27 № 01/186  
Төв

Санал хүргүүлэх тухай

Тус газар нь барилга, дэд бүтцийн салбарт төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх байгууллагын хувьд салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах, хяналтын байгууллагын чадавхыг дээшлүүлэх, хяналт шалгалтын даваагчдыг аригтах зорилгоор "Барилга, дэд бүтцийн салбарын болон бусад салбарын хяналтын тогтолцоог сайжруулах хөтөлбөр", "Барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам"-ын төслүүдийг боловсруулж хүргүүлсэн билээ.


Нийслэлийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/1459 дугаар захирамжаар "Хяналт шалгалтын эрх зүйн орчныг сайжруулах санал, зөвлөмж боловсруулах" үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд хяналт шалгалтын үр нөлөөг байдан, улсын байцагчийн шийдвэрийн хэрэгжилт, үр дүнг дээшлүүлэх, салбарын хяналт шалгалтын байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, барилга дэд бүтцийн салбарт орлолцогчдын хариуцлагыг нэмэгдүүлэх, эрх зүйн орчныг боловсруулах болгох шаардлагын хүрээнд зарим хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, хэвсгэлтээр хүргүүлэв.

Уг асуудлыг болон дарах шийдвэрийн төслүүдийг хууль тогтоомжийн дагуу хянан шийдвэрлүүлж өгөхийг хүсье.

Хэвсгэлт 15 хуудастай.



Хяналт шалгалтын газар  
Урьдлага  
Даргын амбан уурийг тус орчны гүйцэтгэгч  
Самантат Захирагч  
2025.02.28 13:51



Хяналт шалгалтын гэрээний 2025 оны 02 дугаар сарын 25 өдөр үйлчилж хэвсгэлт

**ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ ХҮРЭЭНД ХУУЛЬ ТОГТООМЖИД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ САНАЛ**

Улаанбаатар хот

№	Хүчин төгөлдөр үйлчилж буй хэмжээ	Нэмэлт, өөрчлөлт оруулах санал	Үндэслэл, тайлбар
<b>Төрийн хяналт шалгалтын тухай хууль</b>			
1	Байхгүй	9.1 Хяналт шалгалтын байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. <b>"9.1.6 баталгаажсан үр дүн бүхий хяналтын үйлчилгээг үзүүлэх зорилгоор итгэмжлэгдсэн лабораторийг байгууллагын дэргэд байгуулж болно" гэж нэмэлт оруулах</b>	Төрийн хяналт шалгалт нь иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад чиглэж бөгөөд уг эрхийг хангахын тулд аливаа үйл ажиллагаа нь стандарт, норм дүрмд нийцж байгаа эсэхийг техник технологи, багаж хэрэгслэйн тусламжтайгаар тогтоох боломжтой. Гэтэл Монгол улсын хэмжээнд лабораторийн хүртээмж маш бага төдийгүй үйл ажиллагаа явуулж буй лабораторийн чадавхи сул байна. Ингэснээр хяналт шалгалтын ажил удааширч, улсын байцагчийн дүгнэлт баримт нотлох шалжлах ухаанд үндэслэлгүйгээр нийцвэрээр баталгаажих нөхцөл бүрдэж буй учир лабораторийг байгуулах эрхийг хяналт шалгалтын байгууллагад олгох эрх зүйн үндсийг бүрдүүлж, данган хөгжүүлэх нь зүйтэй.
2	Байхгүй	10 дугаар зүйл Улсын байцагч, түүний нийтлэг бүрэн эрх. <b>"10.9.14 Энэ хуулийн 10.9.8-т заасан шаардлагын дагуу арга хэмжээ авахаг бол албан тушаалтын албан тушаалаас нь огцруулах, чөлөөлөх, хуулийн этгээдийн зөвшөөрлийг цуцлах саналыг</b>	Улсын байцагчийн шийдвэрийг иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь заавал биелүүлэх үүргтэй боловч тогтоомжор бүрэн тодорхойлогдоогүй байна. Тухайлбал Зөрчил шалтан шийдвэрлэх тухай хуулийн дагуу тухайн зөрчлөөс шалгаалж эрх бүхий албан тушаалтан нь хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг цуцлуулах саналыг холбогдох байгууллагад хүргүүлэх

Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 03 дугаар тогтоолоор “Нийслэлийн хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох, судалгаа шинжилгээ хийх, санал дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг” байгуулагдаж, тус газрын удирдлага ажлын хэсгийн ахлагчаар томилогдсон. Ажлын хэсгийн хүрээнд 8 хууль тогтоомжийн 36 зүйл, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 01/890 дугаартай албан бичгээр Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд, мөн 01/891 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргад тус тус хүргүүлсэн.



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД**

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР

Навсэндэн зам 1200, Ардатын ам, 23 дугаар хороо, Хөвсгөл дүүрэг, Улаанбаатар хот, Т-1100  
Утас: 0976 7011 8030, 7011 6940  
Цахим хуудас: www.standart.mn.gov.mn

2025.09.12 № 01/991  
Төв

Хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах санал хүргүүлэх тухай


Хяналт шалгалтын эрх зүйн орчныг боловсруулах болгох, улсын байцагчийн шийдвэрийн хэрэгжилт хяналт шалгалтын үр нөлөөг байдан сайжруулах, барилга, дэд бүтцийн салбарт орлолцогчдын хариуцлагыг нэмэгдүүлэх, алига, ашиг сонирхлын зөрчлийг бууруулахаар холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, хэвсгэлтээр хүргүүлэв.

Дээрх саналыг хууль тогтоомжийн дагуу хянан шийдвэрлүүлж өгөхийг хүсье.

Хэвсгэлт 18 хуудастай.



Хяналт шалгалтын газар  
Урьдлага  
Даргын амбан уурийг тус орчны гүйцэтгэгч  
Самантат Захирагч  
2025.09.12 16:23



Хяналт шалгалтын гэрээний 2025 оны 09 дугаар сарын 12 өдөр үйлчилж хэвсгэлт



**ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ ХҮРЭЭНД ХУУЛЬ ТОГТООМЖИД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ САНАЛ**

Улаанбаатар хот


№	Хүчин төгөлдөр үйлчилж буй хэмжээ	Нэмэлт, өөрчлөлт оруулах санал	Үндэслэл, тайлбар
<b>Төрийн хяналт шалгалтын тухай хууль</b>			
1	Байхгүй	9.1 Хяналт шалгалтын байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. <b>"9.1.6 баталгаажсан үр дүн бүхий хяналтын үйлчилгээг үзүүлэх зорилгоор итгэмжлэгдсэн лабораторийг байгууллагын дэргэд байгуулж болно" гэж нэмэлт оруулах</b>	Төрийн хяналт шалгалт нь иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад чиглэж бөгөөд уг эрхийг хангахын тулд аливаа үйл ажиллагаа нь стандарт, норм дүрмд нийцж байгаа эсэхийг техник технологи, багаж хэрэгслэйн тусламжтайгаар тогтоох боломжтой. Гэтэл Монгол улсын хэмжээнд лабораторийн хүртээмж маш бага төдийгүй үйл ажиллагаа явуулж буй лабораторийн чадавхи сул байна. Ингэснээр хяналт шалгалтын ажил удааширч, улсын байцагчийн дүгнэлт баримт нотлох шалжлах ухаанд үндэслэлгүйгээр нийцвэрээр баталгаажих нөхцөл бүрдэж буй учир лабораторийг байгуулах эрхийг хяналт шалгалтын байгууллагад олгох эрх зүйн үндсийг бүрдүүлж, данган хөгжүүлэх нь зүйтэй.
2	Байхгүй	10 дугаар зүйл Улсын байцагч, түүний нийтлэг бүрэн эрх. <b>"10.9.14 Энэ хуулийн 10.9.8-т заасан шаардлагын дагуу арга хэмжээ авахаг бол албан тушаалтын албан тушаалаас нь огцруулах, чөлөөлөх, хуулийн этгээдийн зөвшөөрлийг цуцлах саналыг</b>	Улсын байцагчийн шийдвэрийг иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь заавал биелүүлэх үүргтэй боловч тогтоомжор бүрэн тодорхойлогдоогүй байна. Тухайлбал Зөрчил шалтан шийдвэрлэх тухай хуулийн дагуу тухайн зөрчлөөс шалгаалж эрх бүхий албан

➤ **Барилга, дэд бүтцийн салбарын хяналтын нэгдсэн цахим системийг хөгжүүлэх хүрээнд: (НЗДҮАХ-5.1.8)**

Төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг цахимжуулах, ил тод байдлыг хангах, үр дүнтэй болгох зорилтын хүрээнд гар утас болон вебд суурилсан “UBInspection – Хяналт шалгалтын аппликейшн” программ хангамжийг хөгжүүлэх ажлыг гүйцэтгэхээр “Промакс” ХХК-тай 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр гэрээ байгуулав. Уг “UB Inspection” цахим системийг хүлээн авч, Нийслэлийн Хяналт шалгалтын газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А/93 дугаар тушаалаар албан ёсоор үйл ажиллагаанд нэвтрүүлэв.



Мөн тус газраас нийслэлийн нутаг дэвсгэр дээрх барилгажилтын үйл ажиллагааг хянах зорилгоор Google Earth Engine платформыг ашиглан хиймэл дагуулын зураг болон хиймэл оюун ухааны загвар, шийдлүүдийг ашиглан зөвшөөрөлгүй барилгын ажлыг алсаас тандан илрүүлэх, хянах системийн судалгаа, туршилтын ажлыг эхлүүлсэн. Энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “И Ти Креатив” ХХК-тай 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдөр “Ажил гүйцэтгэх гэрээ”-г байгуулж, нийслэлийн хэмжээнд зөвшөөрөлгүй барилгажилт өрнөж буй талбайн координатыг таамаглах, газрын ашиглалт, хөрсний нөхцөл байдлын өөрчлөлтийг ажиглах аргачлалыг боловсруулан туршилтын шатанд бэлтгэл ажлыг хангаж байна.



➤ **Барилгын болон автозамын материал, хийц, бүтээц, эзлэхүүний шинж чанарыг тодорхойлох, газрын тос, хийн үзүүлэлтийг хэмжих, сорилт шинжилгээний лаборатори байгуулах бэлтгэл ажлыг хангуулах хүрээнд:** (НЗДҮАХ 5.1.9)

Барилгын болон автозамын материал, хийц, бүтээц, эзлэхүүний шинж чанарыг тодорхойлох, газрын тос, хийн үзүүлэлтийг хэмжих, сорилт шинжилгээний иж бүрэн лаборатори байгуулах төслийн хүрээнд шаардлагатай дагалдах багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, судалгааны үндэслэл болон урьдчилсан төсвийн тооцоог нэгтгэн боловсруулж, 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 01/84 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.

“Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгасан энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг 2026 оны төсөвт тусгуулж, санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр Нийслэлийн Санхүү, хөрөнгө оруулалтын газарт 2025 оны 11 дүгээр сарын 20-ний өдрийн 01/1149 дугаартай албан бичгээр хүргүүлсэн бөгөөд улсын төсвийн орлого бүрдэлтээс шалтгаалан зардлын зарцуулалтын эрх нээгдэхгүй байгаатай холбоотойгоор тус зардлыг санхүүжүүлэх боломжгүй гэсэн хариуг тус газраас ирүүлсэн.

➤ **Улсын (ахлах) байцаагчдыг мэргэшүүлэх багц сургалтын хөтөлбөр баталж, хэрэгжүүлэх хүрээнд:** (Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө)

Нийслэлийн хэмжээнд барилга, дэд бүтцийн салбарын төрийн хяналтын улсын (ахлах) байцаагчдын чадавх, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор тус газрын 42 улсын байцаагчийн мэргэшлийн сургалтын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, холбогдох яам, мэргэжлийн холбоод болон сургалтын байгууллагуудын судалгаанд үндэслэн мэргэшүүлэх багц сургалтын хөтөлбөрийг боловсруулж, 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр газрын даргаар батлуулсан. Хөтөлбөрийн хүрээнд сургалтын төлөвлөгөө гарган дараах сургалтуудад улсын (ахлах) байцаагчдыг хамруулав. Үүнд:

1) Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарын хяналтын улсын (ахлах) байцаагчдын чадавхыг бэхжүүлэх, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, салбарын төрөөс баримтлах бодлого, анхаарах асуудал, хяналт шалгалтын ажлын гүйцэтгэл, үр нөлөөг сайжруулах, болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх, техникийн аюулгүй ажиллагааг хангах, тулгамдаж буй асуудлаар санал солилцох, туршлага судлах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх зорилгоор Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Салбарын хяналтын газар болон Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс хамтран Орон нутгийн улсын (ахлах) байцаагчдыг чадавхжуулах, туршлага солилцох сургалтыг зохион байгууллаа. Тус сургалтыг 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдөр цахимаар, 13-14-ний өдрүүдэд танхимаар явуулж, 18 хяналтын улсын (ахлах) байцаагч, албан хаагч хамрагдсан.

2) Нийслэлийн Прокурорын газраас 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан “Зөрчлийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудал” сэдэвт сургалтад 30 албан хаагч, мөн 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр зохион байгуулсан “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” сэдэвт сургалтад эрх бүхий албан тушаалтнууд тус тус хамрагдсан бөгөөд нийт 2 удаагийн сургалт зохион байгуулагдсан.

3) Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны салбарын аймаг, нийслэлийн улсын (ахлах) байцаагчдыг чадавхжуулах, туршлага солилцох сургалтад хамрагдсан.

4) “Улаанбаатар хотын орон сууцны эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх” (RePaRe) төслийн хүрээнд Монголын барилгын зураг төсөл зохиогчдын холбоотой хамтран

“Барилгын эрчим хүчний хэмнэлтийн үр ашиг” сэдэвт 32 цагийн сургалтыг 2025 оны 03 дугаар сарын 15-23-ны өдрүүдэд зохион байгууллаа. Тус сургалтад нийт 28 байцаагч, албан хаагч хамрагдан мэргэжил дээшлүүлж, гэрчилгээ гардан авсан.



5) “Эн си ди Прекон” ХХК-тай хамтран 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр Хан-Уул дүүргийн 23 дугаар хороонд хэрэгжиж буй “Каса да Винчи”, “Гарден Сити Хаус” төслийн хүрээнд 2-4 давхар угсармал хийцтэй амины сууцыг угсармал бетон эдлэлээр барьж буй төслийн талбай болон үйлдвэртэй танилцах сургалтыг зохион байгууллаа.





## ХОЁР.ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын дагуу газрын үндсэн үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг сар бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлж, тайлагнасан.

2025 оны байдлаар байгууллагын үйл ажиллагаатай холбогдох нийт 30 тогтоол шийдвэрийн 62 заалтыг хяналтад авч ажилласан байна. Хяналтад авсан заалтын хэрэгжилтийг сар бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт тогтоосон хугацаанд нь тайлагнаж, нийт 12 удаагийн тайлан хүргүүлсэн байна.

Хүснэгт. Хяналтад авсан тогтоол шийдвэрийн тоо

Д/д	Шийдвэрийн нэр	Тоо	Заалт
1	Ерөнхийлөгчийн зарлиг	1	1
2	Монгол Улсын Засгийн газрын тогтоол	1	2
3	Монгол Улсын Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	2	2
4	Монгол Улсын Ерөнхий сайдын албан даалгавар	2	2
5	Нийслэлийн Засаг даргын захирамж	12	22
6	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдааны тэмдэглэл	2	5
<b>Нийт:</b>		<b>22</b>	<b>34</b>

### 2.1. Нийслэлийн Засаг даргын захирамж, зөвлөлийн хурлын тэмдэглэл, шуурхай хуралдаанаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулах хүрээд:

Нийслэлийн Засаг даргын ажлын хэсэг байгуулсан болон бусад захирамжуудын хэрэгжилтийг заагдсан хугацаанд тайлагнаж, нийт 9 удаагийн тайланг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Мөн нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан 16 ажлын хэсэгт газрын удирдлага, албан хаагчид томилогдон оролцсон байна.

Захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд зохион байгуулсан арга хэмжээг дурдвал:

➤ **Нийслэлийн Засаг даргын “Агаар бохирдуулагч эх үүсвэрийн судалгаа гаргах, хяналт шалгалт зохион байгуулах тухай” А/33 дугаар захирамжийн хүрээнд:**

Хяналт шалгалтын даргын 2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн “Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай” 02-13-04/23/09 дугаартай удирдамжийн дагуу агаар бохирдуулагч эх үүсвэрийн бүртгэл тооллого, хяналт шалгалтын ажлыг 2025 оны 1 дүгээр сард зохион байгуулж, нийт 37 албан хаагч ажилласан. Хан-Уул дүүргийн 16 дугаар хорооны нутаг дэвсгэрт 3-15кВт хүртэл хүчин чадалтай халаалтын зуух зуух ашиглагч нийт 420 айл өрх, нийслэлийн 7 дүүргийн нутаг дэвсгэрт 15-100кВт-аас дээш хүчин чадалтай усан халаалтын зуух ашиглагч нийт 456 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хяналт шалгалтад хамрагдсан.



Шалгалтаар халаалтын зуухны дэлгэрэнгүй судалгаа гарган, зуухны бүрэн бүтэн байдал, галлагааны аюулгүй ажиллагаа, угаарын хий мэдрэгч төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, агаар бохирдуулагч хориглосон эд зүйлс шатааж буй эсэхэд хяналт шалгалт хийн холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллав. Шалгалтын танилцуулга, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Онцгой комисс, Агаар, орчны бохирдолтой тэмцэх газарт тус тус 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 01/64 дугаар албан бичгээр тус тус хүргүүлэв.

➤ **Нийслэлийн Засаг даргын “Ажлын хэсэг байгуулах тухай” А/214 дүгээр захирамжийн хүрээнд:**

Хяналт шалгалтын газрын даргын баталсан “Нийтийн байрны барилга байгууламжид урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” 02-13-04/23/12 дугаартай удирдамжийн хүрээнд нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж буй нийтийн байруудад 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрөөс 2025 оны 02 дугаар сарын 25-ны хугацаанд хяналт

шалгалтыг зохион байгуулсан. Шалгалтыг дүүрэг тус бүрд дэд ажлын хэсэг байгуулж, нийт 215 албан хаагч оролцож, 8 төрөл, 25 чиглэлээр 770 нийтийн байрыг хамруулсан.




Хяналт шалгалтад хамрагдсан нийтийн байруудыг дүүргээр ангилан авч үзвэл: Сүхбаатар дүүрэгт 53, Чингэлтэй дүүрэгт 151, Баянзүрх дүүрэгт 222, Сонгинохайрхан дүүрэгт 136, Хан-Уул дүүрэгт 31, Баянгол дүүрэгт 167, Налайх дүүрэгт 6, Багануур дүүрэгт 3, Багахангай дүүрэгт 1 нийтийн байр тус тус хамрагдсан байна.



Нийслэлийн 9 дүүргийн нийт 383 иргэн, аж ахуйн нэгжээс авсан судалгааны үр дүнд 175 буюу 45.8 хувь нь хөрсөнд шингээдэг нүхэн жорлонтой, 201 буюу 52.5 хувь нь стандартад нийцсэн, бохир сордог нүхэн жорлон ашиглаж байгаа бол ердөө 7 буюу 2 хувь нь төвлөрсөн бохирын шугамд холбогдсон байна. Мөн нийтийн байрнуудын халаалтын эх үүсвэрийг авч үзвэл 194 байр нь ердийн галлагаатай ханан пийшин, 389 байр нь нам даралтын зуух ашиглаж байгаа нь ихэнх нийтийн байр хатуу түлш ашиглаж байна.


Нийтийн байрны үйлчилгээ эрхлэгчийн үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн орчин сул, төрийн захиргааны байгууллагад бүртгэлгүй, төрийн зохицуулалт, хараа хяналтаас орхигдсон тул байр, үйлчилгээнд тавигдах стандарт шаардлага байхгүй, нэг хүний амьдрах орчны стандарт зөрчигдсөн, байгууламж шатах эрсдэлтэй болон орчны аюулгүй байдал алдагдсан зэрэг нийтлэг нийт 7630 зөрчил илрүүлж, 2334 зөвлөмж, 403 мэдэгдэл, 12 албан шаардлага хүргүүлж, 132 зөрчлийг газар дээр нь арилгуулан ажиллав.



**Нийслэлийн Засаг даргын 2025 оны “Хууль тогтоомжийн хэрэгжилт, орчны аюулгүй байдлыг хангуулах, хотын өнгө үзэмжийг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/237 дугаар захирамжийн хэрэгжилт:**

Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд дэд ажлын хэсэгт нийт 33 албан хаагчийг томилж, 2025 оны 03 дугаар сарын 10-аас 05 дугаар сарын 09-ний өдрүүдэд хуваарийн дагуу 3 хэсэгт хуваагдан гудамж, зам, талбай болон хороодын нийтийн эзэмшлийн зам, талбайн орчны аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулан ажиллалаа.





Хяналт шалгалтын хүрээнд нийтийн эзэмшлийн зам, талбайд зөвшөөрөлгүй байршуулсан барилгын өргөтгөл, шаардлага хангахгүй барилгын түр хашаа, ТҮЦ, хашаа, хайс, зөөврийн байгууламж, зар сурталчилгааны байгууламжуудад улсын байцаагчийн албан даалгавар 22, албан шаардлага 85, зөвлөмж 101, торгууль 12, мэдэгдэх хуудас 1, шаардах хуудас 69-ийг тус тус хүргүүлэв. Мөн хяналт шалгалтын ажлын хүрээнд нийт 435 байршилд шалгалт хийж, 290 зөрчил илрүүлснээс 99 зөрчлийг арилгуулсан.

## **2.2.Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурал, хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилт:**

Байгууллагын үндсэн чиг үүргийн хүрээнд 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 01 дүгээр хуралдаанаар **“Барилга, дэд бүтцийн болон бусад хяналтын салбарын хяналт, шалгалтын тогтолцоог сайжруулах хөтөлбөр”**-ийн төслийг танилцуулсан.

Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, биелэлтийг тухай бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлж тайлагнасан. Үүнд:

- Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 01, 04 дүгээр хуралдааны тэмдэглэлээр өгөгдсөн 4 үүрэг даалгаврын хэрэгжилтийг 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр;
- Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 01 дүгээр хуралдааны тэмдэглэлээр өгөгдсөн 4 үүрэг даалгавар, 07 дугаар хуралдааны тэмдэглэлээр өгсөн 5 үүрэг даалгаврын хэрэгжилтийг 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдөр.

## **2.3.Нийслэлийн удирдлага, газрын удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:**


Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн **23** удаа зохион байгуулагдаж, газрын чиг үүрэгт хамаарах нийт **90** үүрэг даалгавар (үндсэн хэрэгжүүлэх 30) өгөгдөн, 93 хувьтай хэрэгжсэн.

Хүснэгт.Үүрэг даалгаврын тоон үзүүлэлт

Он	Шуурхай хуралдааны тоо	Үүрэг даалгаврын тоо:		Биелэлтийн дундаж
		Нийт:	Байгууллагад өгсөн	
2024	<b>22</b>	<b>587</b>	<b>93</b> (Үндсэн хэрэгжүүлэх-36)	<b>88.6 хувь</b>
2025	<b>23</b>	<b>546</b>	<b>90</b> (Үндсэн хэрэгжүүлэх-30)	<b>93 хувь</b>

2025 оны 1 дүгээр сараас хойш Нийслэлийн шуурхай хуралдаанаар өгөгдсөн 21, мөн Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс 2024-2025 онд өгсөн нийт 42 үүрэг даалгаврын хэрэгжилтийг нэгтгэн, ДХШХ-ийн даргаар баталгаажуулж, НЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт тайлагнасан.

Нийслэлийн Удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнд газрын удирдлага 14 хоног тутамд биечлэн оролцож, нэгжийн дарга, ахлах мэргэжилтнүүд цахимаар буюу Zoom платформуор оролцож, холбогдох мэдээ мэдээллийг авч ажиллалаа.



Нийслэлийн Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А/334 дүгээр захирамжаар баталсан “Шуурхай зөвлөгөөн зохион байгуулах журам”-ын дагуу газрын даргын шуурхай хуралдааныг тухай бүр зохион байгуулж, үүрэг даалгаврыг танилцуулан, хариуцан гүйцэтгэх нэгж, албан тушаалтнуудад үүрэг өгч ажиллав.

Мөн Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн дүүрэг хорооны засаг дарга нартай хийсэн нийт 3 уулзалтаар өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж, биелэлтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тайлагнаж ажилласан.

**Газрын даргын шуурхай хуралдаан:** Шуурхай хуралдааныг нийт **24** удаа зохион байгуулж, нийт **337** үүрэг даалгавар өгөгдсөн бөгөөд үүрэг даалгаврын биелэлтийн дундаж нь 86 хувьтай байна.

Д/д	Хэлтэс	Үүрэг даалгавар (давхардсан тоогоор)	Эзлэх хувь
1	Захиргаа, санхүүгийн хэлтэс	124	41.7%
2	Дотоод хяналт, шинжилгээний хэлтэс	27	9%
3	Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтэс	30	10%
4	Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс	79	26.6%
5	Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтэс	69	23.2%
6	Орчны аюулгүй байдлын хяналтын хэлтэс	30	10%
7	Нийт хэлтэс, албан хаагчдад хамаарах	26	45



#### 2.4. Нийслэлийн Засаг даргаас Засгийн газрын гишүүд, салбарын сайд нартай байгуулсан хамтран ажиллах гэрээнд заасан зорилтуудын хэрэгжилт, үр дүн, тайлагнасан байдал

Монгол Улсын Засгийн газрын гишүүд болон нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн хооронд байгуулсан хамтран ажиллах дараах 6 сайдтай байгуулсан хамтран ажиллах гэрээний хүрээнд байгууллагын эрхлэх асуудал, чиг үүрэгтэй уялдуулан нийт 19 арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/17 дугаар тушаалаар баталсан.

Хүснэгтээр үзүүлбэл:

Д/д	Салбар яамдын сайд	Арга хэмжээний тоо
1	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	2
2	Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хороо	2
3	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	1
4	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд	6
5	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд	3
6	Эрчим хүчний сайд	5
<b>Нийт:</b>		<b>19</b>

Төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийг дараах байдлаар тайлагнаж ажиллав. Үүнд:

- Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдтай байгуулсан гэрээний эхний хагас жилийн биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт цахимаар хүргүүлсэн.
- Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны даргатай байгуулсан гэрээний эхний хагас жилийн хэрэгжилтийг 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 01/535 дугаартай албан бичгээр НЗДТГ-т хүргүүлсэн.
- Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдтай байгуулсан гэрээний жилийн эцсийн хэрэгжилтийг 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 01/1163 дугаартай албан бичгээр НЗДТГ-ын Нийслэлийн бодлого, төлөвлөлтийн газарт хүргүүлсэн.
- Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдтай байгуулсан гэрээний жилийн эцсийн хэрэгжилтийг 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 01/1164 дугаартай НЗДТГ-ын Дэд бүтэц, хөгжлийн бодлогын хэлтэст хүргүүлсэн.
- Эдийн засаг, хөгжлийн сайдтай байгуулсан гэрээний жилийн эцсийн хэрэгжилтийг 2025 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 01/1232 дугаартай албан бичгээр НЗДТГ-ын Нийслэлийн бодлого, төлөвлөлтийн газарт хүргүүлсэн.

- Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтийг 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр ERP цахим системээр НЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлсэн.
- Эрчим хүчний сайдтай байгуулсан гэрээний жилийн эцсийн хэрэгжилтийг 2025 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 01/1231 дүгээр албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.

## 2.5.Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх чиглэлээр хийсэн ажил, үр дүн

Барилгын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоол "Барилга байгууламж ашиглалтад оруулах дүрэм", Нийслэлийн Засаг даргын 2024 оны "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" А/503 дугаар захирамжийн дагуу барилга байгууламж, түүний гадна талбайн тохижилт, засварлах, тоноглох ажлыг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, стандартын шаардлагад нийцүүлэн ашиглалтад оруулах үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллуулах хүсэлтийг 2021 оноос эхлэн төрийн үйлчилгээний нэгдсэн портал [www.e-mongolia.mn](http://www.e-mongolia.mn)-ээр авч байна. Мөн [www.e-business.mn](http://www.e-business.mn), [www.edoc.ulaanbaatar.mn](http://www.edoc.ulaanbaatar.mn) цахим системээр хүлээн авч, иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг ажлын 3-5 хоногт багтаан баримт бичгийн бүрдлийг хянаж, судлан шийдвэрлэж байна. 2025 онд улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл тусламжаар баригдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллуулах нийт 1848 хүсэлт ирүүлсэн.

Д/д	Цахим систем	Ирсэн хүсэлт
1	<a href="http://www.e-mongolia.mn">www.e-mongolia.mn</a>	<ul style="list-style-type: none"> <li>➤ Барилга байгууламж – 439</li> <li>➤ Цахилгаан хангамж – 758</li> <li>➤ Засвар, тохижилт – 16</li> </ul>
2	<a href="http://www.e-business.mn">www.e-business.mn</a>	<ul style="list-style-type: none"> <li>➤ Барилга байгууламж – 116</li> <li>➤ Цахилгаан хангамж – 110</li> </ul>
3	<a href="http://www.edoc.ulaanbaatar.mn">www.edoc.ulaanbaatar.mn</a> (Нийслэлийн дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем)	<ul style="list-style-type: none"> <li>➤ Барилга байгууламж – 140</li> <li>➤ Цахилгаан хангамж – 70</li> <li>➤ Засвар, тохижилт – 199</li> </ul>



НҮҮР

БИДНИЙ ТУХАЙ

ҮЙЛЧИЛГЭЭ

ИЛ ТОД БАЙДАЛ

ХОЛБОО БАРИХ

Комиссын хүсэлт гаргахдаа дараах материалуудын бүрдлийг хангах

- Комисс ажиллуулах хүсэлт. /Захиалагчаас/
- Захиалагчийн барилгын техникийн хяналтын нэгдсэн дүгнэлт
- Зураг төсөл зохиогчийн хяналтын нэгдсэн дүгнэлт
- Барилгын ажил эхлүүлэх зөвшөөрлийн гэрчилгээ

Захиалагч дээрх баримт бичгийн бүрдлийг үнэн зөв, бүрэн гүйцэд ханган доорх хоёр цахим сүлжээгээр ирүүлэх.

ЦАХИМ ХОЛБООС:

<https://e-mongolia.mn/service/barilga-baiguulamjiig-ashiglaltad-oruulakh>

<https://e-business.mn/home>



mongolia  
Цахим үндэстэн



business

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлт илгээхдээ дараах QR кодыг уншуулна уу

QR кодыг уншуулж ашиглалтад оруулах барилга байгууламжийн төрлийг сонгож холбогдох мэдээллийг үнэн зөв, бүрэн гүйцэд бөглөх.



САНАМЖ:


Хэрхэн мэдээлэл оруулах заавар веб хуудсанд байршсан болно.

Мэдээллийг шалган баталгаажуулдаг тул дутуу, алдаатай орсон тохиолдолд комиссын дүгнэлт баталгаажилт удаашрахыг анхаарна уу.



## БАРИЛГА БАЙГУУЛАМЖ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ АЖИЛЛАГААНЫ ҮЙЛ ЯВЦ

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлт шийдвэрлэх 4 үе шатын 3-ыг цахимаар зохион байгуулж ажиллаж байна.




**Хүсэлт хүлээн авч судлах**

🕒 /3-5 хоног/

- ✓ Ирүүлсэн хүсэлт, баримт бичиг, дүгнэлт, барилгын ажлыг хянаж, судлах

Цахим




**Хуваарь боловсруулж, батлуулах**

🕒

- ✓ Долоо хоног бүр комисс ажиллах хуваарь батлуулж цахим хуудсанд байршуулах
- ✓ Комиссын хуваарийг бүрэлдэхүүн байгууллагуудад цахим шуудангийн хаягаар илгээж гишүүн томилуулах
- ✓ Мэдэгдлийг цахим хаягаар хүргүүлнэ

Цахим




**Комисс ажиллах**

🕒 /Хурал үргэлжлэх хугацаа 2цаг/

- ✓ Комиссын хуралдааныг зохион байгуулах
- ✓ Гишүүд саналын хуудсаар даалгавар өгөх
- ✓ Захиалагч, гүйцэтгэгч үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах. /ажлын 14 хоног/

Тухайн объектод ажиллах



**Дүгнэлт баталгаажуулах**

🕒

- ✓ Барилга байгууламжтай холбоотой 130 төрлийн холбогдох мэдээллийг бүртгэдэг
- ✓ Комиссын дүгнэлтийг баталгаажуулж 5% үйлдэж хүлээлгэн өгдөг

Цахим, цаас

## ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

### 3.1. Байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүргийн хэрэгжилт

#### 3.1.1. Барилга, дэд бүтцийн салбарын төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх:


Барилга, дэд бүтцийн салбарын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Хяналт шалгалт хийх нийтлэг журмын дагуу төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг холбогдох яамдын салбарын хяналтын газрын удирдамж болон газрын даргын баталсан хяналт шалгалтын удирдамжийн хүрээнд зохион байгуулж, түүний үр дүнд илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг авч ажиллаж байна.

Д/д	Салбар	Хяналтын чиглэл	Харьяа яамд
1	Барилга	Барилгын техник	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам
2		Хот төлөвлөлт	
3		Өргөх байгууламж	
4		Ус хангамж, ариутгах татуурга	
5		Барилгын материал	
6	Дэд бүтэц	Эрчим хүч (цахилгаан)	Эрчим хүчний яам
7		Эрчим хүч (дулаан)	Зам, тээврийн яам
8		Авто зам	
9		Авто тээвэр	
10		Газрын тос, хий	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам
11		Харилцаа холбоо	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам

## Хүснэгт. Хяналт шалгалтын тоон үзүүлэлт

Д/д	Хяналт шалгалтын төрөл	Объектын тоо
1	Төлөвлөгөөт хяналт шалгалт	175
2	Төлөвлөгөөт бус хяналт шалгалт	2656
3	Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт	1616
4	Гүйцэтгэлийн хяналт шалгалт	862
<b>Нийт:</b>		<b>8014</b>

## Улсын /ахлах/ байцаагчдын үйлдсэн эрх зүйн баримт бичгийн тоо



## ТӨЛӨВЛӨГӨӨТ ХЯНАЛТ ШАЛГАЛТ

Барилга, дэд бүтцийн салбар чиглэлээр салбарын хяналтын <http://shilenkhyanal.gov.mn> цахим системд нийт 178 объектын эрсдэлийн үнэлгээг оруулж, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 79 дүгээр тогтоолоор баталсан “Салбарын хяналт шалгалтын төлөвлөгөө”-ний дагуу их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн нийт 175 объектод хяналт шалгалтыг зохион байгуулав.

Д/д	Хяналтын чиглэл	Объектын тоо	
		Төлөвлөсөн	Гүйцэтгэсэн
1	Хот төлөвлөлт	15	15
2	Барилгын техник	30	30
3	Өргөх байгууламж	20	20
4	Ус хангамж, ариутгах татуурга	10	10
5	Барилгын материал	22	22
6	Эрчим хүч (цахилгаан, дулаан)	20	20
7	Авто зам	10	10
8	Авто тээвэр	20	20
9	Газрын тос, хий	28	28
10	Харилцаа холбоо	-	-
<b>Нийт:</b>		<b>178</b>	<b>175 (98.3%)</b>

**Барилгын техникийн хяналтын чиглэлээр:** 30 аж ахуйн нэгж байгууллагад хяналт шалгалт хийж, бага эрсдэлтэй үнэлэгдсэн 20 хуулийн этгээдэд улсын /ахлах/ байцаагчийн зөвлөмж хүргүүлсэн. Дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 6 хуулийн этгээдэд улсын байцаагчийн 24 заалт бүхий 6 албан шаардлага хүргүүлж, их эрсдэлтэй үнэлэгдсэн 4 хуулийн этгээдэд

Зөрчлийн тухай хуулийн дагуу 20.0 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, ЭБАТ-ын зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.


**Хот төлөвлөлтийн хяналтын чиглэлээр:** 15 ААНБ-д төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, их эрсдэлтэй үнэлэгдсэн 1 хуулийн этгээдэд 10.0 сая төгрөгийн торгууль ногдуулсан. Дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 3 хуулийн этгээдэд 12 заалт бүхий улсын ахлах байцаагчийн албан шаардлага хүргүүлж, бага эрсдэлтэй үнэлэгдсэн 6 хуулийн этгээдэд улсын ахлах байцаагчийн зөвлөмж хүргүүлэв. Үйл ажиллагаа зогссон 5 хуулийн этгээдийг шилэн хяналтын системд бүртгэж ажиллав.

**Өргөх байгууламжийн хяналтын чиглэлээр:** 20 аж ахуйн нэгж байгууллагад хяналт шалгалт хийж, бага эрсдэлтэй гарсан 17 ААНБ-д улсын байцаагчийн зөвлөмж, дунд эрсдэлтэй гарсан 3 ААНБ-д улсын /ахлах/ байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүлэв.

**Барилгын материалын хяналтын чиглэлээр:** 22 аж ахуйн нэгж байгууллагад хяналт шалгалт хийж, их эрсдэлтэй гарсан “Талын төмөр буга” ХХК-д 5.0 сая төгрөгийн торгууль ногдуулсан. Дунд эрсдэлтэй гарсан 9 ААНБ-д улсын ахлах байцаагчийн 27 заалт бүхий хугацаатай албан шаардлага, бага эрсдэлтэй 8 ААНБ-д улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлэв.







**Эрчим хүчний хяналтын чиглэлээр (цахилгаан):** Эрчим хүчний сайдын 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/05 дугаартай тушаал, Салбарын ерөнхий байцаагчийн баталсан 11/03 дугаартай удирдамжийн дагуу шинээр ашиглалтад орж буй барилгын гадна дулааны шугам сүлжээний зураг төсөл, угсралтын байдалд нийт 10 аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийв. Хяналт шалгалтын дүнгээр 5 аж ахуйн нэгж, байгууллагад улсын (ахлах) байцаагчийн 14 заалт бүхий албан шаардлагыг хүргүүлсэн. Тус хяналт шалгалтын танилцуулгыг бэлтгэн 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр газрын даргад танилцуулж, баталгаажуулсан.




**Эрчим хүчний хяналтын чиглэлээр (дулаан):** Эрчим хүчний сайдын 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/05 дугаартай тушаал, салбарын ерөнхий байцаагчийн баталсан 11/03 дугаартай удирдамжийн дагуу шинээр ашиглалтад орж буй барилгын гадна дулааны шугам сүлжээний зураг төсөл, угсралтын байдалд нийт 10 аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийсэн. Хяналт шалгалтаар 1 зөрчлийн хэрэг нээн, хэрэг бүртгэлийн ажиллагаа явуулсан. Мөн 5 аж ахуйн нэгж, байгууллагад улсын (ахлах) байцаагчийн 14 заалт бүхий албан шаардлагыг хүргүүлсэн. Тус хяналт шалгалтын танилцуулгыг бэлтгэн 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр газрын даргад танилцуулж, баталгаажуулсан.

Эрчим хүчний сайдын 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/05 дугаартай тушаал, салбарын ерөнхий байцаагчийн баталсан 11/03 дугаартай удирдамжийн дагуу ДЦС-4 ТӨХК-д Эрчим хүчний яамны холбогдох албан тушаалтнуудтай хамтран төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, улсын ахлах байцаагчийн 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 11-00-01/014/07 дугаартай албан шаардлагыг хүргүүлэн ажилласан.



**Авто замын хяналтын чиглэлээр:** Салбарын улсын Ерөнхий байцаагчийн баталсан 04/03 дугаартай “Төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн хүрээнд дараах хяналт шалгалтыг хийсэн. Үүнд:

- Зайсангийн 225 у/м төмөр бетон гүүрний өргөтгөл, шинэчлэлтийн ажлын гүйцэтгэлд хяналт шалгалт хийж, 04-13-02/040/278 дугаартай албан шаардлагыг гарган гүйцэтгэгч ЗМЗ ХХК-д хүргүүлсэн.
- Сонгинохайрхан дүүргийн Толгойтын авто замыг Ард Аюушийн өргөн чөлөөтэй холбох авто зам, гүүрэн байгууламжийн барилгын ажил болон зураг төсөл, холбогдох баримт бичигт хяналт шалгалт хийж, 04-13-02/040/269 дугаартай албан шаардлагыг гарган Замын хөгжлийн газар, зөвлөх “Эс Ар Пи Консалтинг Монголиа” ХХК-д тус тус хүргүүлсэн.
- Баянгол дүүргийн Голден парк орон сууцны хорооллын хойгуурх туслах авто замын гүйцэтгэгч Бумбат даваа ХХК-д улсын ахлах байцаагчийн 04-13-02/040/446 дугаартай, 4 заалт бүхий албан шаардлагыг хүргүүлсэн.
- Хан-Уул дүүргийн Наадамчдын авто замаас Энхтайваны өргөн чөлөө хүртэлх (I хэсэг) авто замын гүйцэтгэгч Тотал Инж ХХК-д улсын ахлах байцаагчийн 04-13-02/040/445 дугаартай, 5 заалт бүхий албан шаардлага хүргүүлсэн.



Баянгол дүүргийн 9 дүгээр хороонд “Билгүүн бар” ХХК-ийн хэрэгжүүлж буй гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийн ажлын гүйцэтгэлд Хот байгуулалтын хяналтын чиглэлийн улсын байцаагчтай хамтран хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлүүдийг арилгуулахаар 02-13-01/033/275 дугаартай албан шаардлага хүргүүлэв. Сүхбаатар дүүрэгт “Мөнх-Ариун булаг” ХХК-ийн хэрэгжүүлж буй ашиглалтын шаардлага хангахгүй барилгыг буулгаж, дахин төлөвлөх төслийн ажилд төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, Хот байгуулалтын хяналтын чиглэлтэй хамтарсан албан шаардлага хүргүүлэв.

**Автотээврийн хяналтын чиглэлээр:** “Ахуйн хог хаягдлын тээвэрлэлт, нийтийн эдэлбэр газар, хотын гудамж, зам талбайн цэвэрлэгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх тухай” 02-13-04/023/13 дугаартай удирдамжийг боловсруулж, батлуулсан.

Дээрх удирдамжийн дагуу “Сүхбаатар дэвшил” ОНӨААТҮГ, “Сүхбаатар дэвшил менежмент” ОНӨААТҮГ, “Сүхбаатар тохижилт” ХХК, “Эко хотын тээвэр” ААТҮГ, “Хан-Уул агро” ААТҮГ, “Хан эко тээвэр” ААТҮГ, “Баянзүрх эко тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ, “Эймасс” ХХК, “Налайх тохижилт” ОНӨААТҮГ, “Багануур тохижилт” ААТҮГ, “Хан-Уул тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ, “Сонгинохайрхан дүүргийн тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ, “Чингэлтэй дүүргийн тохижилт үйлчилгээ” ХХК, “Элит стэри” ХХК, “ОЧТ” ХХК, “Найши трейд” ХХК, “Багахангай хот тохижилтын алба” ОНӨААТҮГ, “Охь мандал” ХХК, “Баянгол шинэ өргөө” ОНӨААТҮГ, “Улаанбаатар шинэчлэл” ХХК-уудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийв. Шалгалтын хүрээнд дээрх аж ахуйн нэгжүүдийн тээврийн хэрэгсэл хадгалах битүү зогсоол, техникийн засвар үйлчилгээний байр, засварын ажлын тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, нийт 151 автотээврийн хэрэгсэл, машин механизмын техникийн байдалд үзлэг шалгалт хийсэн.



Шалгалтаар нийт 151 зөрчил илрүүлж, үүнээс 18 зөрчлийг газар дээр нь арилгуулж, “Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах тухай” 181 заалт бүхий улсын (ахлах) байцаагчийн 20 албан шаардлага гаргав. Шалгалтын дүнгийн тухай 02-13-04/023/13 дугаартай танилцуулгыг боловсруулж, Газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Мөн шалгалтын дүнг үндэслэн “Санал хүргүүлэх тухай” албан бичгийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 01/389, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газруудад 06/439 дугаар албан бичгээр тус тус хүргүүллээ.

**Газрын тос хийн хяналтын чиглэлээр:** Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан “Төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай” 06-00/001 дугаартай удирдамжийн хүрээнд газрын тосны бүтээгдэхүүний худалдаа, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн газрын тосны бүтээгдэхүүн хадгалах 28 агуулахад төлөвлөгөөт хяналт шалгалт хийв. Шалгалтаар 160 заалт бүхий 28 албан шаардлага хүргүүлж, 10 агуулахад торгох шийтгэл оногдуулан нийт 10 сая төгрөгийн торгуулийн

төлбөрийг бүрэн барагдуулсан. Шалгалтын дүнг 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 06/461 дугаар албан бичгээр холбогдох байгууллагад хүргүүлэн ажилласан.



Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан “Төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай” 06-00/001 дугаартай удирдамж болон тус яамнаас ирүүлсэн албан хүсэлтийн дагуу дахивар бүтээгдэхүүн боловсруулж, газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй аж ахуйн нэгжүүдэд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийсэн. “Дизель план” ХХК, “Эко стандарт петролиум” ХХК, “Алтан оршихуй” ХХК-иуд нь үйл ажиллагаа явуулаагүй байгааг тогтоон, “Алтан оршихуй” ХХК-д батлагдсан ажлын зургийг шалгуулах тухай мэдэгдэл хүргүүлсэн бөгөөд “Алтан оршихуй” ХХК, “Об Ойл индестрал” ХХК, “Хай Би Ойл” ХХК, “Ирмүүн Ойл” ХХК-д тус тус албан шаардлага хүргүүлж, биелэлтэд хяналт тавин ажиллаж байна. Мөн “Төгс билэг инженеринг” ХХК-д 2502000756 дугаартай зөрчлийн хэрэг нээн, хяналтын шатанд явж байна.

**Ус хангамж, ариутгах татуургын хяналтын чиглэлээр:** Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 02-00/04 дугаартай “Төлөвлөгөөт шалгалт хийх тухай” удирдамжийн хүрээнд 10 ААНБ-д ус хангамж, ариутгах татуургын чиглэлийн төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, шалгалтад дунд эрсдэлтэй гарсан 2 ААНБ-д улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүлж, бага эрсдэлтэй гарсан 7 ААНБ-д хууль, стандарт, норм дүрмийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар 02-13-01/041/39 дугаартай Улсын ахлах байцаагчийн зөвлөмжийг хүргүүлэн ажилласан бөгөөд 1 аж ахуйн нэгж нь 2025 онд үйл ажиллагаа явуулаагүй талаар мэдэгдсэн.

### УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЯНАЛТ ШАЛГАЛТ

Барилга, дэд бүтцийн салбарын хяналтын чиглэлээр болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөрчил, дутагдал, хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох зорилгоор нийт **1616 объектод** урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийв.

**Барилгын техникийн хяналтын чиглэлээр:** Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 02-00/07 дугаартай удирдамж, Хяналт шалгалтын газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн “Улс, нийслэлийн хөрөнгө оруулалтаар хийгдэх барилга, байгууламжид урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” 02-13-014/23/04 дугаартай удирдамжийн дагуу 10 аж ахуйн нэгж байгууллагуудад урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийсэн.

Чингэлтэй, Сүхбаатар, Налайх дүүргийн нутаг дэвсгэрт урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар ЕБС-ийн 23 дугаар сургууль, 108 дугаар цэцэрлэг, Налайх, Чингэлтэй дүүргийн 640 хүүхдийн сургуулийн барилга, мөн тус дүүргийн 17 дугаар хорооны

960 хүүхдийн сургууль, 23 дугаар хорооны 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга газар чөлөөлөлтийн ажил хийгдэж байх тул 2025 оны төсөвт суугдаагүй эхлээгүй байсан. Шалгалтын үр дүнд Боловсролын Ерөнхий газар, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газарт болон зохиогч, гүйцэтгэгчид Улсын ахлах байцаагчийн 02-13-01-027/230 дугаартай 6 заалт бүхий албан шаардлага, мөн 2025 оны 01 дүгээр албан даалгаврыг хүргүүлсэн.




Хяналт шалгалтын газрын даргын 2025 оны “Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” 02-13-01/026/15 дугаартай удирдамжийн дагуу Сүхбаатар дүүргийн 14 дүгээр, Чингэлтэй дүүргийн 14, 18 дугаар хороодын нутаг дэвсгэрт “Сэлбэ дэд төв”-ийн төслийн талбарт өртсөн барилгуудын ашиглалт, буулгалт болон газар чөлөөлөлтийн үйл ажиллагаанд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оролцож ажилласан бөгөөд энэхүү шалгалтын үр дүнд Улсын ахлах байцаагчийн 02-13-01/027/73 дугаартай албан шаардлагыг холбогдох байгууллагад хүргүүлсэн.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Боловсролын яамны салбарын улсын ерөнхий байцаагч нарын 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 03-00/12, 02-00/28 дугаартай удирдамжийг үндэслэн, Нийслэлийн Хяналт шалгалтын газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/47 дугаар тушаалаар баталсан “Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн хүрээнд нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад Нийслэлийн боловсролын газрын боловсролын хяналтын улсын /ахлах/ байцаагчид хамтран 2025 оны 08 дугаар сарын 11-ний өдрөөс 08 дугаар сарын 22-ны өдрийг дуустал хугацаанд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн.



Нийслэлийн 9 дүүрэгт нийт 132 боловсролын барилга байгууламжийг хяналт шалгалтад хамруулав. Үүнд: Хан-Уул дүүрэгт 21, Баянзүрх дүүрэгт 20, Баянгол дүүрэгт 11, Сонгинохайрхан дүүрэгт 20, Сүхбаатар дүүрэгт 20, Чингэлтэй дүүрэгт 20, Багануур дүүрэгт 9, Багахангай дүүрэгт 4, Налайх дүүрэгт 7. Шалгалтаар нийт барилгын 65.15% нь ашиглалтын төлөв байдал, орчны аюулгүй байдлын шаардлага хангаагүй зөрчил дутагдал илэрсэн.

Байгууллага	Барилгын тоо	Зөрчилтэй барилга	Хувь (%)
Сургууль	64	48	75
Цэцэрлэг	68	38	55.88
<b>Нийт</b>	<b>132</b>	<b>86</b>	<b>65.15</b>



Зөрчил, дутагдал	Сургууль	Хувь (%)	Цэцэрлэг	Хувь (%)
Гадна тохижилт, тоглоомын талбай, ногоон байгууламж хангалтгүй	21	21.6	23	33.8
Тохижилтын ажил хийгдсэн боловч дутуу, чанаргүй	18	18.5	-	-
Явган зам, авто зогсоол, хөдөлгөөний тэмдэг тэмдэглэгээ хангалтгүй	-	-	18	26.4
Барилгын ашиглалтын шаардлага хангаагүй (дээврийн ус алдалт, суулт, дулаан алдагдал)	12	12.3	14	20.5
Камер, гэрэлтүүлэг хангалтгүй, дохиоллын системгүй	7	7.2	9	13.2

Илэрсэн зөрчил, дутагдлуудад холбогдуулан улсын байцаагч “Стандартын хэрэгжилтийг хангуулах тухай” 132 зөвлөмж, 45 шаардах хуудсаар хугацаатай үүрэг даалгавар, Сонгинохайрхан дүүргийн 15 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “Ирээдүй” сургуульд 2025 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 02-13-01/025/426 дугаартай “Дутууг арилгах тухай” улсын ахлах байцаагчийн албан шаардлага, мөн Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 228 дугаар цэцэрлэгт 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 02-13-01/025/332 дугаартай “Цэцэрлэгийн барилгын дээврийн ашиглалтын

төлөв байдлын тухай” улсын ахлах байцаагчийн дүгнэлт хүргүүлсэн. Боловсролын байгууллагын удирдлага, аж ахуйн ажилтнуудад илэрсэн зөрчил, дутагдлыг бүрэн арилгах, үйл ажиллагаагаа сайжруулах, ашиглалтын үеийн норм, дүрмийн хэрэгжилтийг хангах, аюулгүй ажиллагаа болон техник ашиглалтын дүрмийг мөрдөж ажиллах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Хяналт шалгалтын газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн “Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт зохион байгуулах тухай” А/29 дүгээр тушаалын дагуу нийслэлийн төвийн 6 дүүргийн 20 улсын эмнэлэг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын гадна талбайн тохижилт, явган хүний зам, гадна хаяг, хашаа, гадна шат, довжоо, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлын стандартад хяналт тавьж ажилласан.

Хяналт шалгалтаар дараах нийтлэг зөрчил илэрсэн:




- Барилгын гол хаалга, довжоо ХБИ-нд хүртээмжгүй;
- Явган хүний зам талбай эвдрэлтэй;
- Хашаа хайс стандартын бус эвдрэлтэй, стандарт хангаагүй;
- Хог хаягдал цуглуулах цэг битүүмжлэл алдагдсан;
- Гэрэлтүүлэг хангалтгүй;
- Автомашины зогсоол аюулгүй байдал хангаагүй;
- Үйлчлүүлэгчид зориулсан бүтээн байгуулалт, тохижилтгүй;
- Орц гарц хаагдсан;
- Худгийн таг нээлттэй эрсдэлтэй;
- Орчны цэвэрлэгээ үйлчилгээ хийгдээгүй;
- Гадна хаяг стандартын дагуу хийгдээгүй.




Зөрчилтэй байгууллагуудад хугацаатай үүрэг даалгавар өгч, мөрдөгдөж буй стандарт, хууль, тогтоомж, дүрэм, журмыг танилцуулан мэдээллээр хангаж ажилласан. Нийт 9 байгууллагад хугацаатай үүрэг даалгавар хүргүүлсэн. Үүнээс 5 байгууллага биелэлт ирүүлсэн ба үлдсэн 5 байгууллагад шаардлага хүргүүлэхээр ажиллаж байна. Мөн 6 байгууллага стандартын шаардлага хангасан үзүүлэлттэй байна.

Үүрэг даалгаврын хэрэгжилт, биелэлтийг хангуулсан байдал:

№	Өгөгдсөн үүрэг даалгавар, хэрэгжилт	Өмнө	Дараа
<b>НИЙСЛЭЛИЙН ӨРГӨӨ АМАРЖИХ ГАЗАР</b>			
1	Онгорхой худгийн таг битүүлж, эрсдэл арилгасан.		

<p>2</p>	<p>Хог түр хадгалах цэг шинэчлэн засварлуулсан.</p>		
<p>3</p>	<p>Төрийн байгууллагын нэрийн тэмдэг, хаягийг стандартын дагуу 3 барилгад байршуулав.</p>		
<p><b>БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛЭГ</b></p>			
<p>4</p>	<p>Эмнэлгийн хаягийг стандартын дагуу хүний нүдэнд харагдахуйц шилэн хаалган дээр байршуулсан.</p>		
<p>5</p>	<p>Гол хаалганы довжоог хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хүртээмжтэй болгох</p>		
<p>6</p>	<p>Хог хадгалах цэгийг цэгцлэх</p>		
<p>7</p>	<p>Ил гарсан кабел утас цэгцлүүлэн, зөрчлийг арилгуулав.</p>		
<p>8</p>	<p>Шугам ажлаас сүлжээний үүдэлтэй замын эвдрэл нөхөх</p>		<p>УБЦТС ТӨХК-аас замын нөхөн сэргээлт хийгээгүй.</p>

9	Аж ахуйн хог хаягдал цэвэрлэх		
<b>“СҮХБААТАР” НЭГДСЭН ЭМНЭЛЭГ</b>			
10	Байгууллагын эдэлбэр газрын талбайн хэмжээгээр хүрээлсэн 125 м хашааг угааж, будаж, эвдэрсэн хэсгүүдийг шинэчилсэн.		
11	Хог хаягдлыг түр хадгалах цэгийг битүүмжтэй, ангилан ялгах боломжтой болгох		ангилан ялгах битүүмжлэлтэй, ангилан ялгах тэмдэг бүхий хогийн савыг байршуулахаар захиалга өгсөн талаар мэдэгдэл ирүүлэв.
12	13 байршилд Худгийн тагийг битүүлж, тэгш хэмтэй болгох		
13	Гадна тохижилтын цэвэрлэгээ, ахуйн хог хаягдлыг цэгцлэх		
14	Гол хаалганы шат довжоог ХБИ-д хүртээмжтэй болгох		
<b>ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ</b>			
15	Хог хаягдлын хадгалах цэгийг нүүлгэсэн. Ангилж ялгах хогийн савыг захиалсан.		

16	Аж ахуйн хог хаягдлыг ачуулж, цэвэрлэгээ хийсэн.		
17	Зогсоолыг шинэчлэн засварлах ажил нэгдсэн эмнэлгийн өргөтгөл барих ажлын төлөвлөгөөнд оруулсан.		

**Хот төлөвлөлтийн хяналтын чиглэлээр:** Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Салбарын ерөнхий байцаагчийн баталсан 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 02-00/06 дугаартай “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хэрэгцээ, шаардлагыг хангуулах зорилгоор барилга байгууламжийн зураг төсөл, угсралт, ашиглалтын чанар, аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу орон сууц, олон нийтийн барилга 150, сургууль, цэцэрлэг 25 барилга, нийт 110 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хяналт шалгалт зохион байгуулсан. Шалгалтаар Барилгын техникийн хяналтын улсын байцаагчийн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн барилга байгууламжид тавигдах шаардлага, аюулгүй байдлыг хангуулах тухай” 02-13-01/033/48 дугаартай улсын байцаагчийн зөвлөмжийг барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч нарт хүргүүлсэн.

Хяналт шалгалтын газрын даргын 2025 оны “Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” 02-13-04/023/02 удирдамжийн хүрээнд 7 гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлэгч хуулийн этгээдэд хяналт шалгалт хийж, 2 төсөл хэрэгжүүлэгчид улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж, шалгалтын хүрээнд Сүхбаатар дүүргийн 14 дүгээр хороо, Чингэлтэй дүүргийн 18 дугаар хороонд хэрэгжиж буй Сэлбэ 20 минутын дахин төлөвлөлтийн төслийн хүрээнд Хот байгуулалт, хотын стандартын газарт зөрчил арилгуулах тухай албан мэдэгдэл хүргүүлж ажилласан.

**Өргөх байгууламжийн хяналт шалгалтын чиглэлээр:** Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 02-00/08 дугаартай удирдамж хүрээнд 378 өргөх байгууламжид хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар техникийн аюулгүй ажиллагааны дүрмийг зөрчсөн 28 ААНБ, иргэнд зөрчлийн хэрэг бүртгэлийн ажиллагааг явуулж, 75.9 сая төгрөгийн торгууль оногдуулж, зөрчлийг арилгуулахаар эрх бүхий албан тушаалтны албан даалгавар хүргүүлсэн. Мөн ашиглалтын шаардлага хангахгүй, барилгын талбайд удаан хугацаанд зогссон, үйлдвэрлэгчээс тогтоосон ашиглалтын хугацаа дууссан 4 цамхагт кран, 12 дүүжин

өргүүрийг Улсын ахлах байцаагчийн дүгнэлтээр буулгаж, ашиглалтаас бүрэн хасаж, эрсдэлээс урьдчилан сэргийлж орчны аюулгүй байдлыг хангуулсан.

Хан-Уул дүүргийн 8 дугаар хороонд байрлах, “Би Кэй Ай” ХХК-ийн захиалгатай Эзистаун цогцолбор барилгын талбайд байрлах БНХАУ-д үйлдвэрлэсэн QTZ31.5 маркийн 3тн даацтай цамхагт краныг барилгын талбайд удаан хугацаанд ашиглаагүй улмаас краны даацын төмөрлөг хийц болон суурь, суурийн бэхэлгээний боолтууд зэвэрсэн, ачаа өргөх болон эргэхийн редакторт ус орж зэвэрч гацсан, ачаа болон тэргэнцрийн ган татлагад тасралт үүссэн тул Улсын ахлах байцаагчийн 02-13-03/042/235 дугаартай дүгнэлтээр уг цамхагт краныг буулгаж, ашиглалтаас бүрэн хасах тухай шийдвэрийг эзэмшигч байгууллагад хүргүүлсэн.



**Барилгын материалын хяналтын чиглэлээр:** Нийслэлийн хэмжээнд бетон зуурмагийн үйл ажиллагаа эрхэлж буй 86 аж ахуйн нэгжээс 58 (67%)-ийг хамруулан хяналт шалгалт хийжээ. Үүнээс 32 аж ахуйн нэгжид улсын ахлах байцаагчийн 02-13-01/040/66 дугаартай зөвлөмж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах шаардлагыг биелүүлээгүй дутагдал илэрсэн 10 аж ахуйн нэгжид хугацаатай албан шаардлага хүргүүлж, барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлгүй, тохирлын гэрчилгээгүй 10 аж ахуйн нэгжид зөрчлийн хэрэг бүртгэлийн ажиллагааг явуулж, 50.0 сая төгрөгийн торгууль ногдуулж, гүйцэтгэлийг хангуулах, эрх бүхий албан тушаалтны зөрчил арилгуулах тухай албан даалгавар хүргүүлсэн.



Хяналт шалгалтын газрын даргын баталсан 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн “Явган замын хавтангийн үйлдвэрүүдэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” 02-13-04/23/17 дугаартай удирдамжаар 7 аж ахуйн нэгж байгууллагад шалгалт хийсэн. Шалгалтаар аж ахуйн нэгж байгууллагуудаас дээж авч хөндлөнгийн лабораторид

шинжлүүлж, стандартын шаардлага хангасан дүгнэлт гарсан тул хууль, норм ба дүрэм хангаж ажиллах тухай 02-13-01/040/24, 02-13-01/040/25 дугаартай улсын ахлах байцаагчийн зөвлөмж хүргүүлж ажилласан.



Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны салбарын улсын ерөнхий байцаагчийн 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 02-00/05 дугаартай удирдамжийн дагуу барилгын гол нэр төрлийн материал болох арматур худалдан борлуулж буй 6 аж ахуйн нэгжид урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийсэн. Зөрчил илэрсэн 2 аж ахуйн нэгжид зөрчлийн хэрэг бүртгэл явуулж, 10.0 сая төгрөгийн торгууль ногдуулан гүйцэтгэлийг хангуулж, эрх бүхий албан тушаалтны зөрчил арилгуулах албан даалгавар хүргүүлсэн.

**Эрчим хүчний (дулаан) хяналтын чиглэлээр:** Хяналт шалгалтын газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн “Уурын болон усан халаалтын зуухны техник ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрмийн хэрэгжилтэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” 02-13-04/023/27 дугаартай удирдамжийн дагуу 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 10 дугаар сарын 15-ны өдрүүдэд Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хороо, 20 дугаар хороо, Налайх дүүргийн 7 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 100 кВт-аас дээш хүчин чадалтай 10 аж ахуйн нэгж, байгууллагын 18 уурын болон усан халаалтын зуухнуудад урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийсэн.

Шалгалтаар 1 хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, 5,0 сая төгрөгийн торгууль ногдуулж, 6 аж ахуйн нэгж, байгууллагад улсын байцаагчийн 7 заалт бүхий албан шаардлага хүргүүлсэн. Хяналт шалгалтын танилцуулгыг газрын даргад 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдөр танилцуулсан.




Эрчим хүчний яам, Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн “Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” 11/04 дугаартай удирдамжийн дагуу Хан-Уул дүүргийн 15 дугаар хороонд байрлах “Цэнгэлдэх ОСНААК” ХХК, “Баатардулаан хан” ХХК-ийн эзэмшлийн УДДТ болон дулаан хангамжийн ашиглалтын

төлөв байдал, холбогдох бичиг баримтад үзлэг шалгалт хийж, улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлэн ажилласан.



Мөн “Улаанбаатар Дулааны сүлжээ” ТӨХК-ийн эзэмшлийн дулаан хангамжийн ашиглалтын төлөв байдал, холбогдох бичиг баримтад урьдчилан сэргийлэх үзлэг шалгалт хийж, улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүлэн ажиллав.



**Авто замын хяналтын чиглэлээр:** Зам, Тээврийн хөгжлийн яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 04/05 дугаартай “Урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай” удирдамжийн хүрээнд дараах хяналт шалгалтуудыг зохион байгууллаа. Үүнд:


- Улаанбаатар хотын түгжрэл бууруулах төслийн хүрээнд хийгдэж буй дүүжин тээврийн төслийн барилга угсралтын ажлыг шалгаж, улсын ахлах байцаагчийн зөвлөмж, барилгын түр хашаа, орчны аюулгүй байдлыг шалгаж, улсын ахлах байцаагчийн 04-13-02/040/136 дугаартай албан шаардлага гарган гүйцэтгэгч “Моннис инженеринг ХХК”-д хүргүүлэв.
- Сонгинохайрхан дүүрэг Соёлын төв урд талын авто замын угсралтын төлөв байдалд шалгалт хийж, батлагдсан зураг төсөл зөрчиж авто замын зорчих хэсгийн цахилгааны тулгуур шилжүүлэхгүйгээр асфальтбетон хучилт хийсэн “Баян-Өлзийт зам” ХХК-д Зөрчлийн тухай хуулийн 14.5 дугаар зүйлийн 1 дэх заалтын дагуу торгуулийн арга хэмжээ тооцож, зөрчил арилгах албан даалгавар хүргүүлэв.
- Баянзүрх дүүрэг Сансарын үйлчилгээний төв орчмын тохижилтын ажлыг шалгаж, илэрсэн дутагдлыг арилгуулахаар 04-13-02/040/270 дугаартай албан шаардлага гарган гүйцэтгэгч “Морин сувд” ХХК-д хүргүүлэв.
- Сонгинохайрхан дүүрэг 27 дугаар хороо, 46 байрны ард авто машины зогсоол шинээр байгуулах ажилд шалгалт хийв.

- Баянгол дүүрэг 20 дугаар хороо, Эрчим хүчний гудамжны өргөтгөл, шинэчлэлтийн ажилд шалгалт хийж, зураг төсөл холбогдох баримт бичиг, барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг шалгаж байна.

**Автотээврийн хяналтын чиглэлээр:** Зам, тээврийн яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан "Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай" 04/04 дугаартай удирдамж болон Нийслэлийн Засаг даргын нэгдүгээр орлогч Т.Даваадалай даргын баталсан удирдамжийн дагуу Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянгол, Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт автомашины кузов засварын үйлчилгээ эрхэлдэг "Вьетнам засвар"-ын 43 аж ахуйн нэгж, иргэний үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийв. Шалгалтаар 26 нэр төрлийн 198 зөрчил илрүүлж, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаагүй 5 иргэн, 9 аж ахуйн нэгжид нийт 4.750 мян/төгрөгийн торгууль ногдуулж, 86 заалт бүхий 13 албан даалгавар хүргүүлэв. Шалгалтын дүнгээс үндэслэн Нийтийн тээврийн бодлогын газарт цаашид авах арга хэмжээний санал боловсруулж, албан бичиг хүргүүлэв. Шалгалтын танилцуулгыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт болон Зам, тээврийн яаманд албан бичгээр хүргүүлэв.



Хяналт шалгалтын газрын даргын баталсан 2025 оны "Шингэрүүлсэн шатдаг хийн тээвэрлэлт эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх тухай" 02-13-04/23/28 дугаартай удирдамжийн дагуу Тээврийн цагдаагийн алба, Нийслэлийн Онцгой байдлын газрын албан тушаалтнуудтай хамтран "Юнигаз" ХХК, "Дашваанжил" ХХК, "Горгаз" ХХК, "Синчи газ" ХХК, "Дрийм газ" ХХК, "Хийн тулга" ХХК-ийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийв.




Шалгалтаар дээрх аж ахуйн нэгжүүдийн дулаан зогсоол, 4 автоцистерн, баллонтой шахсан хий тээвэрлэхээр тоногдсон 2 ачаа тээврийн хэрэгслийн техникийн шаардлага, тээвэрлэлтийн нөхцөл хангагдсан байдал, инженер-техникийн ажилтан болон тээвэрлэгч жолооч нарын ажил үүргийн биелэлтийг тус тус шалгасан. Автотээврийн тухай хууль

тогтоомжийг хэрэгжүүлээгүй “Дрийм газ” ХХК-д 1.5 сая төгрөгийн торгууль ногдуулж, техникийн шаардлага хангаагүй 1 тээврийн хэрэгслийн үйл ажиллагааг зогсоолоо.



**Газрын тос хийн хяналтын чиглэлээр:** Аж үйлдвэр эрдэс баялгийн яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан “Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх” 06-00/002 дугаартай удирдамжийн дагуу Зорчигч тээвэр тав ОНӨААТҮГ-ын 1-р бааз, Зорчигч тээвэр нэг ОНӨААТҮГ, Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ, Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ нийт 4 байгууллагын дотоод хэрэгцээний шатахуун түгээх станцад урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ-т 06/13-06/020/81 дугаартай зөвлөмж, 20 заалт бүхий 3 албан шаардлага хүргүүлэн биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.



Аж үйлдвэр эрдэс баялгийн яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2025 оны “Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх” 06-00/003 дугаартай удирдамжийн хүрээнд томоохон зах худалдааны төвүүдээр борлуулж байгаа 220 граммын ахуйн хэрэглээний хийн худалдаа эрхэлдэг Нарантуул ОУХТ, Хархорин, Барс-2, Бөмбөгөр худалдааны төвүүд, Имарт, Номин, М Март, Оргил, Сагеffoug зураг сүлжээ их дэлгүүрүүд нийт 107 иргэн ААН-үүдэд хяналт шалгалт хийж 06/13-06/019/77 дугаартай зөвлөмж хүргүүлж ажилласан. Хяналт шалгалтын тайланг Нийслэлийн Засаг даргын Тамгын Тамгын газар болон, Аж үйлдвэр эрдэс баялгийн яаманд хүргүүлсэн.



## ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС ХЯНАЛТ ШАЛГАЛТ

Тайлант хугацаанд иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн 2825 албан бичиг, 2521 өргөдөл, гомдлын дагуу төлөвлөгөөт бус шалгалт зохион байгуулж, хуулийн хугацаанд хариуг хүргүүлж, шалгалтаар илэрсэн зөрчлүүдэд улсын байцаагчийн эрх хэмжээний хүрээнд 82 зөвлөмж, 431 албан шаардлага, 116 албан даалгавар, 486 дүгнэлт боловсруулж, холбогдох иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлэн, зөрчил гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад нийт 503.5 сая төгрөгийн торгууль ногдуулав.

Төлөвлөгөөт бус хяналт шалгалтын удирдамжийн хүрээнд ногоон байгууламж, автозам, зогсоол, явган хүний зам, гарц, оршин суугчдын амрах болон хүүхдийн тоглоомын талбай зэрэг асуудлаар 1181 өргөдөл хүсэлтээс 510 иргэн, хуулийн этгээдэд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, 1716 зөрчил илрүүлж, 27 иргэн, 29 аж ахуйн нэгжид 235.7 сая төгрөгийн торгууль ногдуулж, 58.5 хувийг бүрэн барагдуулж, 160 заалт бүхий 40 албан шаардлага хүргүүлж, улсын /ахлах/ байцаагчийн 420 заалт бүхий хот төлөвлөлтийн норм, дүрэм хангахгүй 7, барилга байгууламжийн одоогийн төлөв байдалд 42, зураг төсөл, ашиглалтын шаардлага хангасан 33, чанар аюулгүй байдал хангасан 58 нийт 140 дүгнэлт, 75 заалт бүхий хууль тогтоомжийн хэрэгжилт хангуулах тухай 15 зөвлөмжийг гарган хүргүүлсэн ба хуулийн хүрээнд 178 иргэн, хуулийн этгээд албан бичгээр хариу хүргүүлж, 81 иргэн хуулийн этгээдэд зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн байна.

Д/д	Өргөдөл, гомдлын агуулга	Тоо
1	Ерөнхий төлөвлөгөө, барилга хоорондын зай хэмжээ, зөвшөөрөлгүй барилга, зөвшөөрөлгүй газар шорооны ажил, өргөтгөл, хана нураалт, ашиглалтын дүгнэлт	700 гаруй
2	Барилгын чанар, ашиглалт, стандартын зөрчил, цамхагт краны аюулгүй байдал	600 гаруй
3	Дуу чимээ, орчны аюулгүй байдал, инженерийн шугам сүлжээний гэмтэл	500 гаруй
4	Шөнийн цагаар барилга угсралтын ажил гүйцэтгэж буй	200 гаруй
5	Лифт эвдрэл, орц гарц хаах, тоглоомын талбай, орон сууцны үйлчилгээ, халуун-хүйтэн ус зэрэг орон сууцны ашиглалтын асуудлууд	200 гаруй




## ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ

Барилга, дэд бүтцийн салбарын хүрээнд хяналт шалгалтын явцад илэрсэн чиглэлээр илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах чиглэлээр тус газрын улсын (ахлах) байцаагчдын нийт 525 албан шаардлага, 337 албан даалгавар хүргүүлж, гүйцэтгэлийн хяналт шалгалтаар зөрчил дутагдлыг 82.2 хувиар арилгуулав.

### Зөрчлийн талаарх гомдол мэдээлэл, шалган шийдвэрлэх ажиллагаа

Нийслэлийн Хяналт шалгалтын газарт барилга, дэд бүтцийн салбарт хамаарах нийт 369 зөрчлийн тухай гомдол, мэдээлэл бүртгэгдсэний дагуу Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хуулийн хугацаанд зохион байгуулан дараах шийдвэрийг гаргаж, зөрчил гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад нийт 867 сая төгрөгийн торгууль ногдуулсан.

Д/д	Шийдвэрийн төрөл	Тоо
1	Зөрчлийн хэрэг нээсэн	29
2	Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн	324
3	Харьяаллын дагуу шилжүүлсэн	6
4	Хэрэгсэхгүй болгосон	6
5	Хүлээн авахаас татгалзсан	4



### Бүртгэл баталгаажуулалтад хамруулах ажлын хүрээнд:

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу нийт 528 ширхэг лифтэнд бүрэн магадлал хийж, Барилгын тухай хуулийн 47.2.8 дахь заалтын дагуу өргөх байгууламжийн нэгдсэн бүртгэлд нийт 680 өргөх байгууламжийг шинээр бүртгэж оруулав.

Д/д	Төрөл	Тоо ширхэг
1	Автокран	51
2	Цамхагт кран	18
3	Гүүрэн кран	6
4	Лифт	277
5	Урсдаг шат	38
6	Барилгын дүүжинт өргүүр	134
7	Ачаа хүн зөөврийн өргүүр	8
8	Манипуляторт кран	108
9	Сагстай өргөгч	36
10	Бетон зуурмагийн шахуургат төхөөрөмж	4



Зуух, даралтат сав, шугам хоолойн техникийн магадлал, баталгаажуулалт хийж, бүртгэлд хамруулах хүрээнд нийт 39 баталгаажуулж, Витафит инвест ХХК -ийн ашиглалтын шаардлага хангахгүй 1 савыг ашиглалтаас хассан. Мөн 100 кВт-аас дээш хүчин чадалтай усан халаалтын 11 зуух нийт 50 зуух, даралтат сав, шугам хоолойн техникийн магадлалд баталгаажуулалт хийсэн.

Д/д	Байгууллага	Тоо ширхэг
1	“Зорчигч тээвэр нэг” ОНӨААТҮГ	1
2	“Эко Тэлмэн Од” ХХК	3
3	“Сайхан Төмөрт” ХХК	1
4	“Монос” ХХК	1
5	“Очирдагинас” ХХК	5
6	“Би Цэ Трейд” ХХК	10
7	“Витафит Инвест” ХХК	18



**Төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг мэдээлэл, сургалт, арга зүйгээр хангах ажлын хүрээнд:**

Барилгын угсралт, ашиглалт болон дэд бүтцийн салбарт хууль, стандарт, нормын хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд нийт 6 чиглэлээр, 17 удаагийн сургалт зохион байгуулж, 3,574 иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудыг төлөөллийн хамруулав.

- Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/01 дүгээр захирамжаар 2025 оныг “Бүтээн байгуулалтын жил” болгон зарласантай холбогдуулан барилга байгууламжийн ашиглалтыг сайжруулах, орчны аюулгүй байдлыг хангах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор дүүргүүдийн орчны эрүүл аюулгүй байдал, тохижилтод стандарт хангуулах, барилга байгууламжийн ашиглалтыг хариуцагч иргэн, аж ахуйн нэгж, сууц өмчлөгчдийн холбоод, төрийн албан хаагч нарт сургалт зохион байгуулахаар төлөвлөж Хяналт шалгалтын газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн "Сургалт зохион байгуулах тухай" 01/86 дугаартай албан бичгийг дүүргүүдэд хүргүүлсэн. Энэ хүрээнд нийслэлийн төвийн 6 дүүргийн Засаг даргын Тамгын газрын тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсүүдтэй хамтран батлагдсан хуваарийн дагуу 2025 оны 02 дугаар сарын 18-21-ний өдрүүдэд нийт 610 гаруй төрийн албан хаагч, Сууц өмчлөгчдийн холбоодын төлөөллийг хамруулсан сургалт зохион байгууллаа.

Үүнд:

- 1) Баянгол дүүрэг – 200
- 2) Сонгинохайрхан дүүрэг – 80
- 3) Хан-Уул дүүрэг – 80
- 4) Чингэлтэй дүүрэг – 50
- 5) Сүхбаатар дүүрэг – 80
- 6) Баянзүрх дүүрэг – 120



- Барилгын салбарт ажиллагсад, удирдлага, инженер-техник, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны албан хаагчдад хууль эрх зүйн мэдээлэл өгөх, салбарт тулгамдаж буй асуудал болон ослоос урьдчилан сэргийлэх, техникийн аюулгүй ажиллагааг хангах, туршлага судлах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх зорилгоор "Нийслэлийн нутаг дэвсгэрт барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч нарыг чадавхжуулах" сэдэвт сургалтыг 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдөр Нийслэлийн нутгийн захиргааны төв цогцолборын Б блок байрны 2 давхарт, 201 тоот хурлын зааланд зохион байгууллаа.



Сургалтад нийслэлд барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй захиалагч, зураг төсөл зохиогч байгууллагууд, угсралт ажил гүйцэтгэгч 180 гаруй аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл оролцсон байна.




• Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч 2025 оныг “Бүтээн байгуулалтын жил” болгон зарласантай холбогдуулан хотын стандартыг мөрдүүлэх, иргэдийг эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор нийслэлийн дүүргийн хэмжээнд тохижилт, бүтээн байгуулалтын чиглэлээр ажиллаж буй төрийн байгууллагын инженер, техникийн ажилтан болон холбогдох албан тушаалтнуудад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх сургалтыг 2025 оны 07 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулж, 3 агентлаг, 9 дүүргийн 66 алба хаагч оролцлоо. Сургалтаар барилга, дэд бүтцийн салбарт хийгдэж буй ажилд илэрч буй нийтлэг зөрчил, дутагдал, анхаарах асуудал, нийтийн эзэмшлийн зам талбай, эд хөрөнгийг хамгаалах, засварлахад үүсэж буй хүндрэл, бэрхшээлийн талаар мэдээлэл өгч, арга зүйн зөвлөмжийг хүргэв.

Уг сургалтад холбогдох нийслэлийн хэрэгжүүлэгч агентлагийн мэргэжилтэн, хэлтсийн дарга, мэргэжлийн сургуулийн багш, зөвлөх инженерүүд дараах сэдвүүдээр илтгэл тавилаа.

Д/д	Илтгэгч	Байгууллага, албан тушаал	Илтгэлийн сэдэв
1	Б.Найрамдал	Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтсийн дарга	Дэд бүтцийн салбарт гарч буй зөрчил, дутагдал, цаашид авах арга хэмжээний санал
2	С.Мөнхцэлмэг	Хяналт шалгалтын газрын Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч (Барилгын материал)	Барилгын салбарт гарч буй зөрчил, дутагдал
3	Л.Хүрэлтушаа	Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт бүртгэлийн хэлтсийн тохижилт, их засвар хариуцсан мэргэжилтэн	Тохижилтын ажилд илэрч буй асуудлууд, цаашид авах арга хэмжээний санал
4	Д.Адьяа	Хот байгуулалт, хотын стандартын газрын ажлын албаны ахлах мэргэжилтэн	Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө
5	Б.Болор	Хот байгуулалт, хотын стандартын газрын мэргэжилтэн	Хотын стандартын танилцуулга
6	Ц.Ариунаа	ШУТИС, Мэдээлэл холбоо, технологийн сургуулийн холбооны инженерчлэлийн тэнхимийн ахлах багш	Харилцаа холбооны шугам сүлжээ, олон улсын жишиг
7	Ц.Батжаргал	ШУТИС, Барилга, архитектурын сургуулийн автозамын багш	Явган зам, дугуйн замын стандарт, олон улсын жишиг



- 220 граммын ахуйн хэрэглээний хийн худалдаа, зохистой хэрэглээний талаар худалдааны төвүүдийн нийт 57 зохион байгуулагч, менежерт сургалт зохион байгуулж, улсын байцаагчийн зөвлөмж, боршур тарааж ажиллалаа.



- Эрчим хүчний барилга байгууламжийн угсралтын ажлыг гүйцэтгэгч аж ахуйн нэгж, байгууллагуудад зориулан Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагаанд гардаг нийтлэг зөрчил, дутагдал, гарч болох эрсдэлийн тухай танилцуулга бэлтгэн сургалт зохион байгууллаа. Сургалтад 20 аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл хамрагдав.



- Зам, Тээврийн яам, Монголын Авто замчдын холбоотой хамтран Авто зам, замын байгууламжийн барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 50 аж ахуйн нэгжийн 80 удирдлага, инженер-техникийн ажилтнуудад “Авто замын барилгын ажлын явцад илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга зам, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ” сэдэвт сургалт зохион байгууллаа.



- Зам, Тээврийн яамны Салбарын хяналтын газрын авто замын хяналтын улсын ахлах байцаагч Ш. Гэрэлт-Одтой хамтран, мэргэшсэн инженерийн зэрэг сунгах сургалтад оролцож буй 81 захирал, инженер-техникийн ажилтнуудад Авто зам, замын байгууламжийн зураг төсөл, барилга угсралтын ажилд гардаг нийтлэг зөрчил, дутагдал сэдэвт сургалтыг Монголын Авто замчдын холбооны сургалтын танхимд зохион байгууллаа.

- Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээ эрхлэгчдэд зориулсан сургалтыг Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар, Онцгой байдлын хэлтэс, Нийтийн тээврийн бодлогын газартай хамтран 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр зохион байгууллаа. Сургалтад авто үйлчилгээ эрхлэгч 30 орчим иргэн оролцож, “Авто үйлчилгээ эрхлэхэд мөрдөгдөж буй хууль тогтоомж, үйл ажиллагааг шалгах хяналтын хуудасны талаарх зөвлөмж” сэдвээр танилцуулга хийв. Мөн сургалтад оролцогчдоос ирүүлсэн асуултад хариулт өгч, “Авто үйлчилгээний талаарх зөвлөмж”-ийг тараан ажиллав.



- Нийслэлийн Хяналт шалгалтын газраас нийслэлийн 8 дүүргүүдийн сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуулийн удирдлага, хангамж үйлчилгээний ажилтнуудад зориулан “Барилга байгууламжийн ашиглалт, орчны аюулгүй байдлыг хангах, инженерийн дэд бүтцийн аюулгүй ажиллагааг сайжруулах нь” сэдэвт сургалтыг 2025 оны 11 дүгээр сарын 04-07-ны өдрүүдэд зохион байгууллаа. Сургалтад Хан-Уул, Чингэлтэй, Сонгинохайрхан, Баянгол, Сүхбаатар, Налайх, Багахангай, Багануур дүүргийн сургууль цэцэрлэгийн 384 удирдлага, албан хаагч хамрагдлаа.



### 3.1.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг зохион байгуулах

Барилгын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоол "Барилга байгууламж ашиглалтад оруулах дүрэм", Нийслэлийн Засаг даргын 2024 оны "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" А/503 дугаар захирамжийн дагуу барилга байгууламж, түүний гадна талбайн тохижилт, засварлах, тоноглох ажлыг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, стандартын шаардлагад нийцүүлэн ашиглалтад оруулах үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.

- Барилга байгууламж (бага, дунд, өндөр төвөгшилтэй)
- Их засвар, тохижилтын ажил
- Инженерийн барилга байгууламж (цахилгаан, шугам сүлжээ)

Ашиглалтад хүлээн авсан барилга байгууламжийн тоон мэдээлэл:

Д/д	Он	Барилга байгууламж	Цахилгаан хангамж	Их засвар, шинэчлэлт, тохижилт	Нийт
1	2020 он	218	290	336	<b>844</b>
2	2021 он	396	560	341	<b>1297</b>
3	2022 он	381	580	347	<b>1308</b>
4	2023 он	247	483	215	<b>945</b>
5	2024 он	270	765	162	<b>1197</b>
6	2025 он	329	488	102	<b>919</b>
<b>НИЙТ</b>		<b>1841</b>	<b>3166</b>	<b>1503</b>	<b>6510</b>

Тайлант хугацаанд улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл тусламж, хувийн хэвшлийн байгууллагын хөрөнгөөр хэрэгжсэн барилга байгууламжийг ашиглалтад оруулахтай холбоотой иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн нийт 1632 хүсэлтийг судалж, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэн ажилласан.


Барилга байгууламжийн хүсэлтийн тоон үзүүлэлт

Д/д	Үзүүлэлт	2024 он	2025 он
1	Газрын даргын 2024 оны А/09 тушаалын дагуу урьдчилсан үзлэгт хамруулсан	230	428
2	Татгалзаж шийдвэрлэсэн хүсэлт	211	291
3	Судалж буй барилга, байгууламж	22	31
4	Комиссын хуваарьт оруулсан барилгын тоо	392	615
5	Баталгаажсан дүгнэлт	265	324
6	Нийт ирсэн хүсэлт	599	719

Татгалзсан хүсэлтийн хууль зүйн үндэслэл

Д/д	Хууль, дүрэм	2024 он	2025 он
1	ЗГ-ын 212 тогтоолын 10.3 дахь заалт	4	19
2	Барилгын тухай хуулийн 37.6 дахь заалт	135	123
3	Барилгын тухай хуулийн 48.5 дахь заалт	72	149
<b>Нийт</b>		<b>211</b>	<b>291</b>

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын даргын 2024 оны А/09 “Удирдамж, арга зүйгээр хангах тухай” тушаалын хүрээнд комисс ажиллуулах хүсэлт ирүүлсэн **467** барилга байгууламж дээр урьдчилсан үзлэгийн үйл ажиллагааг зохион байгуулан газрын удирдлагуудад илтгэх хуудсаар танилцуулан ажилласан.



**Ашиглалтад орсон барилгын орон зайн мэдээллийн сангийн бүрдэл**


Орчны аюулгүй байдлын мэдээллийн санг тайлант хугацаанд орон сууцны болон олон нийтийн 324 барилга байгууламжийн мэдээллээр баяжуулан дүгнэлтийг баталгаажуулсан.

Д/д	Мэдээллийн санд бүртгэсэн төрөл	2024 он	2025 он
1	Үйлчилгээтэй орон сууц	79	42
2	Аялал жуулчлалын цогцолбор	34	36
3	Орон сууц	41	79
4	Сургууль, цэцэрлэг /цогцолбор/	0	17
5	Сургууль	9	8
6	Цэцэрлэг	21	14
7	Эмнэлэг	9	12
8	Бусад	72	116
<b>Нийт</b>		<b>169</b>	<b>324</b>

Гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу нийт 64 аж ахуйн нэгж, байгууллагын 109 блок, 9426 айлын орон сууцны комиссын үйл ажиллагааг зохион байгуулж, барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулсан.

Үүнд:

- Баянзүрх дүүрэгт 30 блок (3357 айл),
- Хан-Уул дүүрэгт 11 блок (1029 айл),
- Баянгол дүүрэгт 9 блок (1072 айл),
- Сонгинохайрхан дүүрэгт 23 блок (941 айл),
- Сүхбаатар дүүрэгт 25 блок (3027 айл).




### 3.2. Газрын үндсэн чиг үүрэгтэй холбогдох хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, үр дүн

Дээд шатны байгууллагаас ирүүлсэн дараах хууль тогтоомж болон холбогдох дүрэм, журмын төслүүдэд санал боловсруулан хүргүүлэв. Үүнд:

- Барилгын ерөнхий хуулийн төсөл;
- Орон сууцны болон орон сууцны бус зориулалттай байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн менежментийн тухай хуулийн төсөл, үзэл баримтлалын төсөл;
- Дулаан хангамжийн тухай хуулийн төсөл;
- Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
- Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль;
- Сууц өмчлөгчдийн холбооны үлгэрчилсэн дүрэм;
- Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам.

Түүнчлэн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хүрээнд салбарын чиг үүрэгт хамаарах дараах дүрэм журам, албан бичиг, нөлөөллийн шинжилгээг боловсруулж, дээд шатны байгууллагад хүргүүлэв. Үүнд:

- “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын ажиллах зардлын жишиг хэмжээг барилга байгууламжийн төвөгшил, хэмжээг харгалзан тогтоох тухай” албан бичгийг боловсруулж, Нийслэлийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 01/1227 дугаар албан бичгээр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдад хүргүүлсэн;
- Барилгын ажил гүйцэтгэх явцад үүсэж болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх, барилгын талбай болон түүний гаднах эрсдэлтэй бүсийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн холбогдох хууль, тогтоомж, стандартын хэрэгжилтэд хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулах зорилгоор “Нийслэл дэх барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам”-ын төслийг боловсруулж, мэргэжлийн холбоод болон төрийн бус байгууллагуудаас санал авч нэгтгэн, нөлөөллийн шинжилгээний хамт 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 01/242 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.
- Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн төслийг шинэчлэн боловсруулж, олон нийтээс санал авах зорилгоор байгууллагын цахим хуудас [www.inspection.ub.gov.mn](http://www.inspection.ub.gov.mn)-д байршуулсан.



### 3.3. Үндсэн чиг үүргийн хүрээнд нийслэлийн удирдлагад хууль, эрх зүйн дэмжлэг үзүүлэх, хууль, шүүхийн өмнө төлөөлөх

Хариуцсан чиг үүргийн хүрээнд байгууллагыг шүүхэд төлөөлөх үүргийг хэрэгжүүлж, захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд байгууллагыг төлөөлж нийт 16 хэрэг, маргаанд хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр хууль тогтоомжийн дагуу оролцсон. Үүнээс:

- Бүрэн шийдвэрлэгдсэн маргаан: 9
  - Нэхэмжлэгчийн талд шийдвэрлэгдсэн: 4 (44.4%)
  - Хариуцагчийн талд шийдвэрлэгдсэн: 5 (55.5%)
- Хянан шийдвэрлэгдэх шатанд байгаа маргаан: 7

### 3.4. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын дагуу байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг нийт 4 бүлэг, 35 зорилт 95 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаар батлуулж, Хариуцлагын гэрээг байгуулсан. 2025 оны эхний хагас жил; Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай байгуулсан 2025 оны Хариуцлагын гэрээний биелэлт 96.8 хувь, байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан 95.3 хувьтай тус тус хэрэгжиж, 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 01/540 дүгээр албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. 2025 оны жилийн эцсийн байдлаар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай байгуулсан 2025 оны Хариуцлагын гэрээний биелэлт 97.6 хувь, байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан 97.6 хувьтай тус тус хэрэгжиж, 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 01/1206 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлсэн.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар:

№	Бүлэг	Зорилт	Арга хэмжээ	Үүнээс:			Хэрэгжилт хувь
				85 буюу түүнээс дээш	70-85 хүртэл хувь	70 хүртэл хувь	
1	Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ	15	18	15	1	2	92.2
2	Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ	14	57	57	-	-	98.5
3	Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ	5	15	15	-	-	100
4	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах хүрээнд хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ	1	5	5	-	-	100
Нийт:		35	95	92	1	2	97.6

Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/905 дугаар захирамжаар хагас жилийн гүйцэтгэлийг “**Бүрэн хангалттай**” гэж үнэлсэн бол Нийслэлийн Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн “2025 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг дүгнэх тухай” А/1811 дүгээр захирамжаар жилийн эцсийн гүйцэтгэлийг “**Бүрэн хангалттай**” үнэллээ.

### 3.5. Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө болон нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт, төсвийн гүйцэтгэл

Зөрчлийн тухай хуулийн дагуу барилга, дэд бүтцийн хяналтын улсын байцаагчдын тавьсан торгууль, шийтгэврийн орлогыг Нийслэлийн төсөв (100200000911-Хүү, торгуулийн орлогын данс)-т төвлөрүүлж байна. 2025 онд нийт 400,000,000 төгрөгийн орлогыг нийслэлийн төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөснөөс 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар нийт 634,000,000 сая төгрөгийг Төрийн сангийн дансанд төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 160 хувиар биелүүлсэн. Энэхүү орлогод холбогдох анхан шатны баримт болох Зөрчлийн хэрэг шийдвэрлэсэн шалтгаан бүхий шийтгэлийн хуудас (маягт 1, маягт 2)-ыг бүрдүүлж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төсвийн орлогын ахлах мэргэжилтэнд хүргүүлэн ажиллав.

Санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, төсвийн зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж, санхүүгийн тайлан мэдээг тухай бүр хугацаанд нь тайлагнаж, шинээр авлага, өр төлбөр үүсгээгүй, он дамжсан, насжилт өндөртэй өр, авлага үүсгээгүй ажилласан. Төсвийн гүйцэтгэлийн 2025 оны 11 дүгээр сарын мэдээгээр байгууллагын батлагдсан төсөв 3,371,472.7 мянган төгрөг, гүйцэтгэл 2,894,740.5 мянган төгрөг буюу 85.9 хувьтай байна.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйл “Төсвийн цаглавар”-ын дагуу сар бүр төсвийн гүйцэтгэлийн мэдээ, улирал бүр санхүүгийн болон татварын тайланг хугацаанд нь үнэн зөв гарган, холбогдох байгууллагуудаар баталгаажуулан ажиллав. Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01/87 дугаар албан бичгээр хүргүүлсэн "2025 оны төсвийг нэмэгдүүлж тодотгол хийлгүүлэх тухай" хүсэлтийн дагуу, Нийслэлийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/552 дугаар захирамжаар тус байгууллагын төсвийг 218.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, холбогдох ажлыг хэрэгжүүлэн ажиллав.

Төсвийн гүйцэтгэлийн 2025 оны 11 дүгээр сарын мэдээгээр байгууллагын батлагдсан төсөв 3,371,472.7 мянган төгрөг, гүйцэтгэл 2,894,740.5 мянган төгрөг буюу 85.9 хувьтай байна.

Д/д	Үзүүлэлт	Төсөв	Гүйцэтгэл	Хувь
1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	2,593,011.7	2,204,673.9	85,0
2	Ажил олгогч НДШ	328,559.4	272,874.9	83,1
3	Байр ашиглалт	35,742.1	27,454.7	76.3
4	Эд хогшил, урсгал засвар	267,612.9	255,366.4	95.4
5	Бусдаар гүйцэтгүүлэх, ажил үйлчилгээ	13,156.0	11,686.6	88.8
6	Бараа үйлчилгээний бусад зардал	51,427.0	50,902.4	99.0
7	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	22,000.0	13,100.0	59,5
<b>Дүн:</b>		<b>3,371,472.7</b>	<b>2,894,740.5</b>	<b>85.9</b>

Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс НИТХ-ын даргын 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/52 дугаар захирамжаар нийт 215,000,000 төгрөгийн санхүүжилт олгогдсон. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн ажлын албаны санхүүжилт нэмэлтийн дансны орлогыг зориулалтын дагуу зарцуулан тайланг 2005 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 01/656 дугаар албан бичгээр хүргүүлэв.

Төсвийн тухай хуулийн “8 дугаар зүйл.Төсвийн цаглавар”-ийн дагуу төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ (10 удаа), санхүүгийн тайланг (3 удаа) хуулийн хугацаанд үнэн зөв гарган Нийслэлийн санхүү, хөрөнгө оруулалтын газарт хүргүүлж тайлагнан ажилласан.

Байгууллагын албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах зорилгын хүрээнд дараах гүйлгээг гаргаж, анхан шатны баримтын бүрдлийг ханган ажиллав. Үүнд:

- Бичиг хэргийн материал: 11,617,375 төгрөг
- Компьютер, техник хэрэгсэл, принтер засвар, хор цэнэглэх, авто засвар, өрөө тасалгаа хуваах зэрэг зардал: 23,739,780 төгрөг
- Хэвлэмэл хуудас хэвлэл: 6,636,330 төгрөг
- Сургалтын өрөөнд тавилга, албан хаагч нарын хэрэгцээнд багаж, техник хэрэгсэл: 191,039,100 төгрөг
- Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл: 40,587,500 төгрөг

2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн саналыг боловсруулан 01/687 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын санхүү хөрөнгө оруулалтын газарт хүргүүлсэн. Төсвийн төсөлд хяналт шалгалтын чиглэлээр зардлын нэмэлт санал боловсруулан 2025 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 01/1012 дугаар албан бичгээр болон 12 дугаар сарын 05-ны өдрийн 01/1216 дугаар албан бичгүүдээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газарт тус тус хүргүүлж шийдвэрлүүлэн ажилласан.

### **3.6. Төрийн захиргааны албан хаагчдын ажлын гүйцэтгэл, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэсэн байдал**

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”, 2023 оны 301 тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны “Аргачлал, загвар батлах тухай” 98 дугаар тушаалын дагуу албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх ажлыг Үнэлгээний баг зохион байгуулж, 2025 оны эхний хагас жилийн ажлын гүйцэтгэл, үр дүнгийн үнэлгээний дагуу Нийслэлийн Хяналт шалгалтын газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн “Гүйцэтгэлийн урамшуулал олгох тухай” А/57 дугаар тушаалаар төрийн захиргааны 39, төрийн үйлчилгээний 16, нийт 55 албан хаагчид холбогдох урамшууллыг тооцож олгосон. Жилийн эцсийн байдлаар газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Гүйцэтгэлийн урамшуулал олгох тухай” А/109 дүгээр тушаалаар төрийн захиргааны 37, төрийн үйлчилгээний 17, нийт 54 албан хаагчид холбогдох урамшууллыг тооцож олгосон.

### **3.7. Хяналт шалгалтын байгууллагаас ирүүлсэн санал зөвлөмж, түүнийг хэрэгжүүлсэн байдал**

Нийслэл дэх Төрийн аудитын газарт байгууллагын 2024 оны санхүүгийн тайланг хүргүүлж, аудит хийлгэн, 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 01/265 албан бичгээр “Өөрчлөлтгүй” дүгнэлтийг хүлээн авсан. Нийслэл дэх Төрийн аудитын газраас ирүүлсэн байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжийн биелэлтийг нэгтгэн 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 01/1122 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн.

Нийслэлийн Дотоод аудитын албанаас өгсөн 2023, 2024 оны үйл ажиллагаанд хийсэн дотоод аудит, хяналт, шалгалтын зөвлөмжийн хэрэгжилтийг 98 хувьтай хангаж, 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр 01/1179 дугаартай албан бичгээр тус газарт хүргүүлсэн.

### **3.8. Үндсэн чиг үүргийн биелэлт, үр дүнд хийсэн дотоод аудит, хяналт шалгалт, дүгнэлт**

2025 оны байдлаар дараах дотоод хяналт шалгалтын ажлуудыг зохион байгуулж, үр дүнг холбогдох удирдлага, нэгжүүдэд танилцуулан, санал зөвлөмж хүргүүлж ажилласан.

**1. Улсын комиссын үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалт:** 2024 онд 108 Улсын комисс хүлээн авсан баримт бичигт түүвэрчилсэн хяналт шалгалт хийж, 11 комиссын үйл ажиллагаанд зөрчил илэрснийг тогтоон холбогдох арга хэмжээ авсан.

**2. Албан хаагчдын ажлын байрны хяналт:** 4 албан хаагчийн ажлын байранд зураг авалт хийж, дүгнэлтийг байгууллагын даргын зөвлөлийн хуралд танилцуулсан.

**3. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хяналт:** 2025 оны эхний 4 сарын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдалд хяналт шалгалт хийж, дүнг танилцуулсан. 2025 оны 08 дугаар сарын 18-аас 09 дүгээр сарын 05-ны өдрийг хүртэлх хугацаанд 6 хэлтсийн албан хаагчдыг хамруулан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг 5 чиглэл, 12 шалгуур үзүүлэлтээр шалгаж, илэрсэн зөрчил, сайжруулах шаардлагатай асуудлаар зөвлөмж хүргүүлсэн.

**4. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагаанд хийсэн хяналт:** Газрын даргын 2025 оны А/53 дугаар тушаалын дагуу 2025 оны 06 дугаар сарын 25-аас 07 дугаар сарын 09-ний өдрийн хооронд барилгын ажлын зөвшөөрөлгүй болон баримт бичгийн бүрдэл хангаагүй барилга байгууламжийг ашиглалтад оруулж буй эсэхэд хяналт шалгалт хийж, дүнг газрын шуурхай хуралд танилцуулан, Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтэст зөвлөмж, авах арга хэмжээний санал хүргүүлсэн.

**5. Албан хаагчдын цагийн бүртгэл, ажлын цаг ашиглалтад хийсэн хяналт:** Газрын даргын 2025 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн удирдамжийн дагуу 2025 оны 08 дугаар сарын 18-аас 08 дугаар сарын 29-ний өдрийн хооронд 6 хэлтсийн нийт албан хаагчдын цагийн бүртгэл, ажлын цаг ашиглалтад хяналт шалгалт зохион байгуулж, дүнг 2025 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн газрын шуурхай хуралд танилцуулсан.

#### **6. Хэлтсүүдийн үйл ажиллагаанд хийсэн дотоод хяналт:**

Газрын даргын баталсан “Дотоод хяналт шалгалт зохион байгуулах тухай” удирдамжийн дагуу хэлтсүүдийн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлж буй төрийн хяналт шалгалтын үйл ажиллагаа, хууль эрх зүйн хэрэгжилтийн байдалд холбогдох чиглэл, шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн дотоод хяналт шалгалтыг зохион байгуулж, шалгалтын дүнгийн дагуу санал, зөвлөмж хүргүүлэн ажилласан.

Д/д	Хэлтсийн нэр	Чиглэл, шалгуур үзүүлэлт	Хамрагдсан хугацаа
1	Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтэс	9 чиглэл, 33 шалгуур үзүүлэлт	2025.09.10-2025.10.10
2	Орчны аюулгүй байдлын хяналтын хэлтэс	5 чиглэл, 10 шалгуур үзүүлэлт	2025.10.29-2025.11.07

### **Албан хаагчдын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:**

Эрх бүхий албан тушаалтнууд иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлээгүй, шийдвэрлэх явцад зөрчил гаргасан, тайлан мэдээг дээд шатны байгууллагад хугацаанд нь хүргүүлээгүй зөрчлүүдэд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

- *Сахилгын сануулах арга хэмжээ:* Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын дагуу нийт давхардсан тоогоор хяналтын шар хуудас-40, улаан хуудас-4, нийт 44 албан хаагчид сануулах арга хэмжээ тооцсон.
- *Захиргааны болон бусад арга хэмжээ:* Дээд шатны байгууллага болон АТГ-аас ирүүлсэн 3 удаагийн дүгнэлтийн дагуу 2 албан хаагчид захиргааны арга хэмжээ тооцсон. Нийслэлийн Прокурорын газраас ирүүлсэн зөрчлийн шинжтэй 4 удаагийн мэдээллийн дагуу 2 албан хаагчид сануулах арга хэмжээ авсан. Тухайн албан хаагчдад дахин зөрчил гаргахгүй байх талаар заавар зөвлөмж өгч, арга зүйгээр ханган ажилласан.

### **3.9. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт**

**3.9.1. Хүний нөөцийн удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:** Хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой тайлант хугацаанд **128** тушаал шийдвэр боловсруулж, санал авч, баталгаажуулан ажилласан.

Үүнд:

- Ажилд томилсон- 66
- Ажлаас чөлөөлсөн- 27
- Сахилгын шийтгэл оногдуулсан- 9
- Чөлөө олгосон- 6
- Нэмэгдэл олгосон- 12
- Бусад- 8

Сул орон тоог нөхөн бүрдүүлэх зорилгоор UB ERP системд нийт 3 удаа зар тавьж, материалаа ирүүлсэн 28 нэр дэвшигчтэй ярилцлага зохион байгуулан, Төрийн албаны тухай хууль болон “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын дагуу 15 албан хаагчийг шилжүүлэн ажиллуулсан.

2025 оны байдлаар албан тушаалд дэвшүүлэн томилсон-2, ажлаас чөлөөлсөн 28, байгууллага хооронд шилжин ажилласан-2, нэгж хооронд шилжүүлэн ажилласан 13 нийт шилжилт хөдөлгөөн хийгдсэн байна.

**Албан тушаалын тодорхойлолт боловсруулж, батлуулах хүрээнд:** Нийслэлийн Хяналт шалгалтын газрын 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/63 дугаар тушаалаар албан тушаалын тодорхойлолт боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан. Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 03 дугаар тогтоолоор батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам батлах тухай”-ын дагуу нийт 50 албан тушаалын тодорхойлолтын төслийг боловсруулж дууссан. Үүнд:

- шинээр батлуулах-11,
- өөрчлөн батлуулах (байгууллагын нэр өөрчлөх)-37,
- хэлтсийн нэр өөрчлөн батлуулах-2.

Одоогоор өмнө батлагдсан албан тушаалын тодорхойлолттой харьцуулсан харьцуулалт, бүтцийн харьцуулалтыг хийсэн ба чиг үүргийн шинжилгээ хийж, албан тушаалын тодорхойлолтын төслийн танилцуулгыг боловсруулан Төрийн албаны зөвлөлийн нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна.

**Цагийн бүртгэл хөтлөх, хяналт тавих хүрээнд:** Байгууллагын ажилтан, албан хаагчдын ирц, цагийн бүртгэлийг сайжруулах зорилгоор “Timely.mn” цахим цаг бүртгэлийн системийг 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн нэвтрүүлж, хяналт тавин ажиллаж байна. “Тек Стрим” ХХК-тай байгуулсан үйлчилгээний гэрээний дагуу 2025 оны 08 дугаар сарын 18-ны өдөр Timely цаг бүртгэлийн системийн админ эрхийг нээж, албан хаагчдын цагаа бүртгүүлэх ажиллах байршлыг Google Map дээр радиусаар тохируулан нийт 5 байршлыг үүсгэсэн. Албан хаагчдын цаг бүртгэлийн Timely системийн ашиглалтын байдалд тогтмол дүн шинжилгээ хийж, холбогдох санал, дүгнэлтийг Газрын даргад танилцуулж байна.

**Ээлжийн амралт олгох хүрээнд:** Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу албан хаагчдын ээлжийн амралт, орлон ажиллах хуваарийг газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн Б/12 дугаар тушаалаар баталсан. Батлагдсан хуваарийн дагуу албан хаагчдад ээлжийн амралтын ажил хүлээлцүүлэн, мэдэгдэх хуудас олгон ажиллалаа.

**Хяналтын улсын байцаагчийн эрх олгуулах, цуцлуулах саналыг холбогдох Төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх, шийдвэрлүүлэх хүрээнд:** Хяналтын улсын байцаагчийн эрх олгуулах 12 хүсэлтийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Эрчим хүчний яам, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газарт тус тус хүргүүлж, нийт 7 байцаагчийн эрхийг олгосон. Мөн улсын байцаагчийн эрх цуцлуулах 3 хүсэлтийг Зам, тээврийн яам болон Эрчим хүчний яаманд хүргүүлж, цуцлуулсан.

**3.9.2. “Хяналт шалгалтын газрын албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн хүрээнд:** Нийслэлийн Хяналт шалгалтын газрын албан хаагчдын амьдралын нөхцөл, ажиллах орчин, нийгмийн баталгаа, тулгамдсан асуудал, ирээдүйн хэрэгцээг тодорхойлоход чиглэгдсэн судалгааг нийт 61 албан хаагчийг хамруулан 6 бүлэгт хуваан нийт 31 асуултаар явуулсан. Судалгааны үр дүнд үндэслэн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах нийслэлийн Хяналт шалгалтын газрын 2025-2028 онд хэрэгжүүлэх “Төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг боловсруулж, газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/28 дугаар тушаалаар баталсан.

Хөтөлбөрийн зорилтууд:

<b>Зорилт 1</b>	Албан хаагчдыг хөгжүүлэх, албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэх мэдлэг, мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамруулах.
<b>Зорилт 2</b>	Албан тушаалын цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, дэмжлэг, шагнал, урамшууллыг хууль тогтоомжийн дагуу олгох.
<b>Зорилт 3</b>	Албан хаагчийг ажиллах орчин нөхцөлөөр хангах, сайжруулах, шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах.
<b>Зорилт 4</b>	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах.
<b>Зорилт 5</b>	Албан хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамт олны эвсэг уур амьсгалыг бүрдүүлэх.
<b>Зорилт 6</b>	Албан хаагчдыг орон сууцаар хангах, амьдрах нөхцөлийг сайжруулах боломжийг судалж, шаардлагатай зохицуулалтыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх.

Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 6 зорилтын 24 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр Газрын даргаар батлуулсан.



БАТЛАВ  
НИЙСЛЭЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
ГАЗРЫН ДАРГА АЛБАН ХААГЧИЙГ ТҮР  
ОРЛОН ҮЙЦЭТГЭВ  
С.ЭНХБАЯР  
2025 оны 03 дугаар сарын 31

НИЙСЛЭЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ,  
НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 оны 03 дугаар сарын 31

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хугацаа	Санхүүжилт (мян.төг)	Хариуцах нэгж
<b>Зорилт 1: "Албан хаагчдыг хөгжүүлэх, албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэх мэдлэг, мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамруулах" хүрээнд</b>						
1.1	Албан хаагчдын боловсрол, туршлага, хэрэгцээг шаардлагыг судлан "Сургалтын төлөвлөгөө"-г боловсруулан хэрэгжүүлэх	Сургалт хамрагдсан албан хаагчийн тоо, хэрэгжилтийн хувь	65	I-IV улирал	11,760.0	Хүний нөөцийн сургалт, судалгаа хариуцсан мэргэжилтэн
1.2	Төрийн албаны зөвлөл, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төв, мэргэжлийн байгууллага болон бусад байгууллагаас зохион байгуулах сургалтад хамруулах	Сургалт зохион байгуулсан байгууллага, албан хаагчийн тоо	3-4 байгууллага, 65 албан хаагч	I-IV улирал	Сургалт зохион байгуулсан байгууллагын зардлаас	Захиргаа, санхүүгийн хэлтэс
1.3	Төрийн албан хаагчийг албан тушаалын мэргэжлээр зохих багц сургалт (Удирдлагын академи)-д хамруулах	Сургалтын тоо, хамрагдсан албан хаагчийн тоо	3-5 албан хаагч	I-IV улирал	-	Захиргаа, санхүүгийн хэлтэс
1.4	Албан хаагчдыг мэргэшлийн зэрэг горилох болон сунгах сургалтад хамрагдах боломжоор хангах	Мэргэшлийн зэрэг амжилттай хамгаалсан буюу сунгуулсан албан хаагчийн тоо	2-оос дээш албан хаагч	I-IV улирал	-	Захиргаа, санхүүгийн хэлтэс

Улаанбаатар хот

### Албан хаагчдын ажлын үр дүнг сайжруулах, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх хүрээнд:

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын 2025 оны сургалтын үйл ажиллагааны төлөвлөгөөнд 7 зорилт, 38 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусган 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр газрын даргаар батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллалаа. Албан хаагчдын мэдлэг, ур чадвар, ёс зүй, мэргэшлийг тасралтгүй хөгжүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор холбогдох байгууллагуудтай хамтран сургалт, арга хэмжээг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж ажиллав. Тус сургалтын төлөвлөгөөний 2025 оны жилийн эцсийн биелэлт 99.47 хувийн хэрэгжилттэй байна.

Д/д	Зорилт	Сургалтын сэдэв, арга хэмжээ (тоо)
1	Хууль тогтоомж, стандарт, нормын мэдлэгийг нэмэгдүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх	4
2	Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдүүлэх, ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх	2
3	Архив, албан хэрэг хөтлөлт, компьютер, үндэсний монгол бичгийн чадварыг дээшлүүлэх	5
4	Албан хаагчдын мэдлэг, ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх, мэргэшүүлэх	10
5	Албан хаагчдад мэдлэг олгох ажлын байран дахь сургалт	4
6	Гадаад улсад туршлага судлах, гадаад хэлний мэдлэг чадварыг дээшлүүлэх	2
7	Төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг мэдээлэл, сургалт, арга зүйгээр хангах	11
<b>Нийт:</b>		<b>38</b>

Худалдан авах ажиллагааны АЗ сертификатын сургалт, Архив албан хэрэг хөтлөлтийн сургалт болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн

хөгжлийн төвөөс сар бүр зохион байгуулагддаг сургалтуудад давхардсан тоогоор 70 гаруй албан хаагчдыг хамруулав

Хяналт шалгалтын газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/05 дугаар тушаалаар баталсан “Мэдээллийн цаг”-ийн хуваарийн дагуу 28 удаагийн сургалт, арга хэмжээ зохион байгуулж, давхардсан тоогоор 263 албан хаагчийг хамруулсан байна.



**Албан хаагчдын цалин хөлс, зэрэг дэвийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд:** Нийслэлийн Хяналт шалгалтын газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн А/03 дугаар тушаалаар төрийн үйлчилгээний 21 албан хаагч цалинг хувиар, 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн А/60 дугаар тушаалаар төрийн захиргааны 6 албан хаагч цалинг тус тус нэмэгдүүлсэн.

Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/578 дугаар захирамжийг үндэслэн газрын даргын тушаалаар 10 албан хаагчид төрийн захиргааны албан хаагчдад олгох зэрэг дэв, түүний нэмэгдлийг олгож байна.

**Өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ахмад ажилтнуудад хүндэтгэл үзүүлэх хүрээнд:** Хяналт шалгалтын газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/08 дугаар "Байгууллагын ахмадуудад хүндэтгэл үзүүлэх тухай" тушаалыг үндэслэн, Сар шинийн баярыг тохиолдуулан тус байгууллагад ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан 22 ахмад ажилтанд хүндэтгэл үзүүлж, урамшуулал олгосон.

Газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн “Байгууллагын ахмадуудад хүндэтгэл үзүүлэх тухай” А/81 дүгээр тушаалын дагуу байгууллагад ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад ажилтнуудыг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр хүлээн авч, дурсгалын зүйл гардуулан хүндэтгэл үзүүлэв.



**Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх хүрээнд төрөлжсөн болон багц шинжилгээнд хамруулах хүрээнд:** Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлэг болон Эрүүл мэндийн 13 дугаар төвтэй хамтран 2025 оны 02 дугаар сарын 11-ээс 03 дугаар сарын 13-ны хооронд нийт 50 албан хаагчийг эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрууллаа. Уг арга хэмжээ тус дүүргийн Нэгдсэн эмнэлгийн Яармаг дахь салбар амбулаторид зохион байгуулагдаж, албан хаагчид эрүүл мэндийн 5 төрлийн шинжилгээнд хамрагдсан. Мөн “Монос” ХХК-тай хамтран “Эрүүл мэндийн өдөрлөг” нээлттэй арга хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр зохион байгуулж, эрдсийн шинжилгээ, арьс оношилгоо, ясны сийрэгжилт, шүдний эмчийн үзлэг гэсэн 4 төрлийн эрүүл мэндийн үзүүлэлтээр оношилгоо, үзлэгийг хийсэн.



**Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдад олгож байгаа орон сууцны дэмжлэгт албан хаагчдыг хамруулах хүрээнд:** Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны А/185 дугаар тушаалаар батлагдсан “Албан тушаалын орон сууцанд хамрагдсан оршин суугчдын дагаж мөрдөх журам”-ыг нийт албан хаагчдад танилцуулж, тус журмын дагуу орон сууцанд хамрагдахаар сонгогдсон 4 албан хаагчийн баримт бичгийг бүрдүүлэн, 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 01/531 дүгээр албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Уг хөтөлбөрт хамрагдсан 4 албан хаагчийн 2 нь эхний ээлжийн орон сууцанд хамрагдаж, үлдсэн 2 албан хаагч нь дараагийн ээлжид хамрагдахаар хүлээгдэж байна.

**Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг сайжруулах хүрээнд:** Байгууллагын албан хаагчдын ажил үүргээ хэвийн гүйцэтгэх нөхцөлөөр хангах, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор шаардлагатай тоног төхөөрөмж, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэл, багаж хэрэгсэл, бичиг хэргийн хэрэгслээр хангаж ажилласан.

Д/д	Төрөл	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо хэмжээ (ширхэг)
1	Компьютер, тоног төхөөрөмж	Суурин компьютер	14
		Зөөврийн компьютер	10
		Принтер	6
		Сканнер	3
		Таблет	15
		Камер	2
		Байцаагчийн энгэрийн камер	15
		Цаас устгагч	2
2	Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэл, багаж	Зуны ажлын хүрэм	87
		Салдаг дотортой куртка	87
		Хөдөлмөр хамгааллын гутал	40
		Толгой хамгаалах каск хэрэгсэл	20
		Усны гутал	50
		Хамгаалалтын малгай	70
		Хөдөлмөр хамгааллын гутал	15
		Хийн маск	5
		Чийг нэвтэрдэггүй хамгаалалтын бээлий	20
		Өдөр тутмын хамгаалалтын бээлий	500
		Лифт, урсдаг шатны дуу чичиргээ, хурд хэмжигч	1
3	Тавилга, эд хогшил	Хурлын сандал	50
		Хурлын ухаалаг индер	1
		Хурлын микрофон	8



**Албан хаагчдыг шагналд тодорхойлох, шийдвэрлүүлэх хүрээнд:** Тулгар төр байгуулагдсаны 2234, Их Монгол Улс байгуулагдсаны 819, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 114, Ардын хувьсгалын 104 жилийн ойг тохиолдуулан нийт 18 албан хаагчид шагнал гардуулав.

Д/д	Шагналын нэр	Албан хаагчийн тоо
1	Төрийн дээд шагнал “Алтан гадас одон”	1
2	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны “Тэргүүний барилгачин цол тэмдэг”	1
3	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны “Жуух бичиг”	4
4	Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын “Хүндэт өргөмжлөл”	1
5	“Нийслэлийн Тэргүүний ажилтан” цол тэмдэг	5
6	Нийслэлийн Засаг даргын “Жуух бичиг”	7

Төрийн дээд шагнал, салбарын шагнал, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн нэрэмжит шагналаар шагнуулах хүрээнд нийт 32 хүсэлтийг холбогдох байгууллагад хүргүүлснээс 24 албан хаагчийг шагнууллаа.

Д/д	Шагналын төрөл	Албан хаагчийн тоо
1	Төрийн дээд шагнал	1
2	Нийслэлийн шагнал	11
3	Салбарын шагнал	10
4	Бусад	2



### Гадаад харилцаа, хамтын ажиллагааны чиглэлээр

Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах болон байгууллага хоорондын гэрээ байгуулахтай холбоотой Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тогтоол, зөвлөмжийг мөрдөж, гадаад харилцаатай холбоотой бүх үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж, мэдээ, тайланг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцааны газарт тайлагнан ажиллаж байна.

**Албан уулзалтын хүрээнд:** БНСУ-ын Архитекторын холбооны гишүүн, зөвлөх архитектор Ким Дохён болон “Line A G” компанийн захирал А.Оюунбаатар тэргүүтэй төлөөлөгчдийг газрын удирдлагууд 2025 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр хүлээн авч уулзан, туршлага судлах, цаашдын хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар санал солилцсон.



**Гадаад томилолт:** Бүгд Найрамдах Солонгос Улсын Хэнам хотын Засаг захиргааны газар, Сөүл хотын Архитекторын холбоо, “Банбэ 6” дахин төлөвлөлтийн барилга угсралтын ажлын “Хяналтын хороо”, Сам Вүү барилга угсралтын компанийн төлөөллүүдтэй хамтран, тус газрын холбогдох чиг үүргийн асуудал хариуцсан нийт 8 албан хаагч 2025 оны 04 дүгээр сарын 20-25-ны өдрүүдэд албан томилолтоор ажилласан. Цаашид нийслэл Улаанбаатар хотын хот төлөвлөлт, барилга, дэд бүтцийн салбарын хяналтын тогтолцоог сайжруулах хүрээнд тус улсын барилгын салбарын хууль эрх зүйн орчин, барилгын зөвшөөрөл олгох болон ашиглалтад оруулах үйл явцын талаарх туршлагыг судалсан.



2025 оны 10 дугаар сарын 18-26-ны өдрүүдэд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга А.Баяр тэргүүтэй төлөөлөгчид Америкийн Нэгдсэн Улсын Юта мужийн Солт Лэйк хотод албан ёсны айлчлал хийж, айлчлалын хүрээнд НИТХ-ын дарга А.Баяр болон Солт Лэйк хотын захирагч Женни Вилсон нар хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурсан. Уг арга хэмжээнд Барилга байгууламжийн ашиглалт бүртгэлийн хэлтсийн дарга А.Мөнгөн оролцож, нийслэлийн зарим ижил чиг үүрэгтэй байгууллагын үйл ажиллагаатай танилцсан.



Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын өөртөө засах орны Хөх хотын барилга, дэд бүтэц, хот байгуулалтын тогтолцоо, стандартын хэрэгжилт, дэвшилтэт технологийн талаарх туршлага судлах зорилгоор 2025 оны 11 дүгээр сарын 03-07-ны өдрүүдэд нэр бүхий 10 албан хаагч томилолтоор ажилласан. Томилолтын явцад албан хаагчид Хөх хотын Зам тээврийн хөрөнгө оруулалтын групп, Орон сууц, Хот хөдөөгийн хөгжлийн төв, Хотын метро удирдлагын төв, Хотын ухаалаг хотын удирдлагын төв, Хот төлөвлөлтийн музей, “Тианхао” шилэн утас үйлдвэрлэх хүнд үйлдвэр зэрэг байгууллагын ажлын байр, үйлдвэрлэлийн талбайтай тус тус танилцсан.



**Сургалт семинар:** Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Хайдерабад хот дахь Англи хэлний болон гадаад хэлний их сургууль (EFLU)-ийн “Англи хэлний мэдлэг дээшлүүлэх” олон улсын сургалтын хөтөлбөрт 2025 оны 07 дугаар сарын 01-28-ны өдрүүдэд Захиргаа, санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн М.Гачмаа хамрагдсан.

Мөн БНХАУ, Тайвань улсын Таёонг хотод 2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдрөөс 10 дугаар сарын 03-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Дэд бүтцийн хөгжил ба төлөвлөлт” сэдэвт сургалтад Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч С.Мөнхцэлмэг томилогдон суралцсан. Тус сургалтад хамрагдсан 21 улс орны төлөөллүүд өөрийн улсыг сурталчлан таниулах зорилготой 10 минутын танилцуулга бэлтгэн илтгэл тавьсан. Шилдэг илтгэгч, шилдэг танилцуулгыг шалгаруулж, Монгол Улсын талаарх танилцуулга илтгэл дэд байр эзэлж амжилттай оролцсон.



**Байгууллагын дэргэдэх зөвлөлүүдийг шинэчлэн байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх, тайлагнах хүрээнд:**

Байгууллагын дэргэдэх 10 зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж, 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан. Байгууллагын дэргэдэх 7 зөвлөлийн бүрэлдэхүүнтэй уулзалт хийж, зөвлөлүүдийн үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилт, гишүүдийн идэвх оролцоо, тулгамдаж буй асуудлуудын талаар харилцан мэдээлэл солилцсон. Уулзалтын үеэр зөвлөл бүрт төлөвлөсөн ажлуудаа эрчимжүүлэх, үйл ажиллагаагаа ил тод, идэвхтэй зохион байгуулах, олон нийтэд сурталчлан таниулах, тайлагнах талаар үүрэг чиглэл өгсөн.



- 1) Залуучуудын зөвлөл;
- 2) Эцэг эхийн зөвлөл;
- 3) Биеийн тамир спорт хамтлаг;
- 4) Эрсдэлийн удирдлагын баг;
- 5) Өмч хамгаалах байнгын зөвлөл;
- 6) Хүний эрх, жендерийн зөвлөл;
- 7) Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл.



Зөвлөлүүдийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг 08 дугаар сарын 27-ны өдөр болон 10 дугаар сарын 03-ны өдөр тус тус 2 удаа нэгтгэж, газрын даргад танилцуулсан. Зөвлөлүүдийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлыг товч дурдвал:

➤ **Залуучуудын зөвлөл:** Байгууллагын албан хаагчдын төрсөн өдрийг тэмдэглэх “Birthday Calendar”-ийг боловсруулж, мэндчилгээ дэвшүүлэх ажлыг тогтмол зохион байгуулж байна.

➤ **Хүний эрх, жендерийн зөвлөл:** Байгууллагын хэмжээнд “Хүний үнэ цэнэ, шударга ирээдүй” хоёр сарын аяныг зохион байгуулж, Хүний эрхийн түгээмэл тунхаглалын постер болон “Хүний эрх ба жендер” сэдэвт видео танилцуулгыг байгууллагын мэдээллийн самбар болон дотоод группт байршуулан сурталчлан ажиллав. Хүний эрхийн Үндэсний Комиссын ахлах референт Э.Мөнхзулыг урьж албан хаагчдад “Хүний эрх ба Жендер” сургалтыг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулж 45 албан хаагчийг хамруулав.



➤ **Эцэг эхийн зөвлөл:** Ажилтнуудын хүүхдийн судалгаа гарган, Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан гар зургийн уралдаан болон хүүхдэд зориулсан өдөрлөг зохион байгуулж, хүүхэд бүрт бэлэг гардуулав.



➤ **Биеийн тамир спорт хамтлаг:** “Тэрбум мод тарих үндэсний өдөр”-ийн хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдөр IGM олон улсын цэцэрлэгт хүрээлэнд 15 ширхэг агч мод, 5 ширхэг монос тарих арга хэмжээг зохион байгуулсан. “Нийслэлийн өвлийн спортын наадам”, “Улаанбаатар марафон 2025” зэрэг арга хэмжээнд ажилтнуудын оролцоог хангуулав.

Албан хаагчдын эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг дэмжих, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх зорилгоор “Байгууллагын аварга шалгаруулах 5 төрөлт спортын тэмцээн”-ийг зохион байгууллаа. И-спорт төрлийг 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр, дартс төрлийг 11 дүгээр сарын 14-ний өдөр, сагс, гар бөмбөг, ширээний теннис төрлийг 11 дүгээр сарын 15-ны өдөр тус тус зохион байгуулж, шилдэг баг, тамирчдыг шалгарууллаа.



➤ **Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл:** “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” сэдэвт дотоод сургалтыг 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулж, нийт 27 ажилтныг хамруулан аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн үндсэн зарчим болон хэрэгжүүлэх шаардлагатай асуудлуудын талаар танилцуулж, хэлэлцүүлэв. Шинээр томилогдсон албан хаагчдад ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дотоод сургалтыг зохион байгуулсан. Мөн байгууллагын “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-г боловсруулж, хянуулахаар Нийслэлийн Онцгой байдлын газрын Гамшгийн шуурхай удирдлагын хэлтэст хүргүүлсэн.

➤ **Өмч хамгаалах байнгын зөвлөл:** Байгууллагын өмч хөрөнгийн бүртгэл, ашиглалт, актлах, үнэлгээний үйл ажиллагааг зохион байгуулах төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/14 дүгээр тушаалын дагуу тус газрын өмчид бүртгэлтэй 50 нэр төрлийн 289 ширхэг тавилга, эд хогшил буюу 243,918,781.41 төгрөгийн үндсэн хөрөнгийг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн анхны хуралдаанаар хэлэлцэж, актлуулах тухай хурлын тэмдэглэл, “Актлах дүгнэлт” үйлдэн актлах саналыг Нийслэлийн

Өмчийн харилцааны газарт хүргүүлж, гарсан шийдвэрийн дагуу акталсан хөрөнгийг хүлээлгэн өгөх үйл ажиллагаанд хяналт тавин ажилласан. Мөн газрын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 71-02 УАЕ, 71-09 УАЕ улсын дугаартай Toyota Prius маркийн 2 автомашинд улсын байцаагчийн дүгнэлт гарсныг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт хүргүүлж, тээврийн хэрэгслийг актлан данс бүртгэлээс хасах тухай хурлын тэмдэглэл үйлдэн хэрэгжилтэд хяналт тавьсан.

Газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/31 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг үндсэн хөрөнгө, бараа материал, эд хөрөнгийн тооллогыг зохион байгуулж, эд хариуцагчийн хөрөнгийн картыг бүртгэлжүүлсэн. Актлахаар санал оруулах хангамжийн материалын жагсаалтыг боловсруулж, байгууллагын удирдлагад танилцуулахаар бэлтгэж, тооллогын комиссын тайлангийн дагуу тооллогын үр дүнг хэлэлцсэн.



Тус зөвлөл нь тайлант хугацаанд нийт 12 удаа хуралдаж, 15 төрлийн асуудлыг хэлэлцэн 3 дүгнэлт, 8 зөвлөмж гаргаж, 2 удаагийн хурлын тэмдэглэлийг баталгаажуулан ажилласан байна.

### **3.10. Архив, албан хэрэг хөтлөлт, хариутай болон хариугүй албан бичгийн шийдвэрлэлтийн байдал**

**3.10.1. Архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр:** Байгууллагын архивын хэвийн үйл ажиллагааг хангах, архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдлөг болгох, нөхөн бүрдүүлэх, арга зүйн зөвлөгөө мэдээллээр хангах, лавлагаа олгох, баримт бичгийг эргэлтэд оруулах, сан хөмрөгийн хадгалалт хамгаалалтад хяналт тавих ажлыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна. Байгууллагын хэмжээнд 2024 онд үүсч хөтлөгдсөн баримтуудыг батлагдсан хуваарийн дагуу хэлтсүүдээс цаасан суурьтай 360 боть, цахим 6 баримтыг шалган үдэж хавтаслан хадгаламжийн нэгж үүсгэн архивт хүлээн авч данс бүртгэл үйлдэх ажлыг хуваарийн дагуу хийж дуусгасан.

Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2024 онд хөтлөгдсөн цаасан суурьтай **360** боть, цахим **6** баримтыг хүлээн авч, хадгаламжийн нэгж үүсгэсэн байна.

- Байнга хадгалах 272 боть;
- Байгууллагад хадгалах 2 боть;
- Түр хадгалах 76 боть;
- 70 жил хадгалах 10 боть.

2024 онд үүссэн захирамжлалын цахим баримт буюу ХШГ-ын А/01-А/87, Б/01-Б/126, ХСХГ-ын А/01-А/24, Б/01-Б/23 тушаалуудыг Archive EDoc программд шивж бүртгэн харьяалах төрийн архивын мэргэжилтэнд хянуулж, 2025 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр төрийн архивт шилжүүлэн акт үйлдсэн.

2025 онд хөтлөгдөх хэтлэх хэргийн нэрийн жагсаалтад хэлтэс нэгжүүдээс санал авч боловсруулж, байгууллагын БНШК-ын 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 02 дугаар хурлаар хянан хэлэлцэж, газрын даргаар батлуулсан.

Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд газрын даргын тушаал болон албан бичгийг хос бичгээр хөтөлж хэвшсэн ба 1150 албан бичиг, 120 тушаалыг монгол бичгээр хөрвүүлж, хэвлэмэл хуудаст буулгав Боловсролын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 1/377 дугаарт албан бичгээр ирүүлсэн “Төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөх тухай зөвлөмж”-ийн хүрээнд 2025 оны 1 дүгээр улирлын тайланг 03 дугаар сарын 26-ны өдрийн 01/253 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэв.

Архив, албан хэрэг хөтлөлт, компьютер, үндэсний монгол бичгийн чадварыг дээшлүүлэх хүрээнд дараах сургалтуудад албан хаагчдыг хамруулав. Үүнд:

- Албан хаагчдын үндэсний монгол бичгийн ур чадварыг сайжруулах зорилгоор нийт албан хаагчдаас монгол бичгийн мэдлэг, хэрэгцээ шаардлагын талаар судалгааг авсан. Үүнтэй холбогдуулан 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдөр байгууллагын 4 албан хаагчид монгол бичгийн анхан шатны мэдлэг олгох сургалтыг зохион байгуулсан.
- Архивчдын сургалт, хөгжил арга зүйн төвтэй хамтран “Архив, албан хэрэг хөтлөлт” сэдэвт сургалтад 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр байгууллагын албан хаагчдыг хамруулсан.
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын зохион байгуулсан 2025 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн Цахим монгол бичгийн сургалтад 6 албан хаагч хамрагдсан.
- Нийслэлийн Архивын газраас 2025 оны 02 дугаар сарын 06, 07-ны өдрүүдэд зохион байгуулсан архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэшүүлэх сургалтад байгууллагын Архивын ажилтан хамрагдсан.

#### **“Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэг”-ийн хүрээнд:**

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн “Улсын үзлэг зохион байгуулах тухай” 23 дугаар тогтоолоор төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгийг 2025 оны III, IV улиралд багтаан улс орон даяар зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Нийслэлийн Засаг даргын 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн “Улсын үзлэг зохион байгуулах тухай” А/1220 дугаар захирамжийн хүрээнд нийслэлийн хэмжээнд улсын үзлэг зохион байгуулах “Нийслэлийн салбар комисс”-ыг байгуулж, үзлэгт хамрагдах байгууллагуудын жагсаалтыг баталсан.

Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт бэлтгэх ажлын хүрээнд ажлын хэсгийн бүрэлдэхүүн, бэлтгэл ажлын төлөвлөгөөг газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/24 дүгээр тушаалаар баталсан. Засгийн газрын 2025 оны 23 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1220 дугаар захирамжийг үндэслэн Хяналт шалгалтын газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн “Улсын үзлэгийн бэлтгэл ажлыг хангуулах тухай” А/78 дугаар тушаалаар 18 хүний хүний бүрэлдэхүүнтэй Ажлын хэсэг байгуулан, бэлтгэл ажлын төлөвлөгөөг шинэчлэн баталж, мөн холбогдох зардлыг баталсан.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн:

<b>Ажлын хэсгийн дарга:</b>	Б.Байгалмаа	Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга
<b>Гишүүд:</b>	Ч.Ариунжаргал	Захиргаа, санхүүгийн хэлтсийн Захиргааны бодлогын хэрэгжилт, хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн
	Б.Сарангэрэл	Захиргаа, санхүүгийн хэлтсийн Хууль, эрх зүй хариуцсан ахлах мэргэжилтэн


	Т.Райса	Захиргаа, санхүүгийн хэлтсийн Хүний нөөцийн сургалт, судалгаа хариуцсан мэргэжилтэн
	Б.Болормаа	Захиргаа, санхүүгийн хэлтсийн Ахлах нягтлан бодогч
	Н.Жигжиддорж	Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн Тохижилт, их засвар хариуцсан улсын байцаагч
	П.Мөнхзаяа	Орчны аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Орчны аюулгүй байдал хариуцсан улсын ахлах байцаагч
	Ш.Байгалмаа	Захиргаа, санхүүгийн хэлтсийн Тооцооны нягтлан бодогч
	Ж.Болор-Эрдэнэ	Захиргаа, санхүүгийн хэлтсийн Бичиг хэргийн эрхлэгч
	Б.Мөрөнгуа	Захиргаа, санхүүгийн хэлтсийн Дотоод ажил хариуцсан ажилтан (Өргөдөл, гомдол хариуцсан ажилтан)
	Б.Эрдэнэтуул	Захиргаа, санхүүгийн хэлтсийн Мэдээлэл технологи, сүлжээ хариуцсан ажилтан
	Э.Мөнхзул	Захиргаа, санхүүгийн хэлтсийн Олон нийт, хамтын ажиллагаа хариуцсан ажилтан
	Г.Мөнхзаяа	Захиргаа, санхүүгийн хэлтсийн Нярав
	Г.Анужин	Дотоод хяналт, шинжилгээний хэлтсийн Эрсдэлийн үнэлгээ, судалгаа хариуцсан ажилтан
	Д.Даваадорж	Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын хяналт хариуцсан ажилтан
	Л.Болормоо	Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтсийн Инженер, техникийн судалгааны ажилтан
<b>Нарийн бичгийн дарга:</b>	М.Гачмаа	Захиргаа, санхүүгийн хэлтсийн Тогтоол шийдвэрийн биелэлт, тайлан хариуцсан ахлах мэргэжилтэн
	С.Мөнхзаяа	Захиргаа, санхүүгийн хэлтсийн Судлаач-архивч

**Урьдчилсан үзлэгийн талаар:** Нийслэлийн Архивын газрын дарга бөгөөд Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын Улсын ахлах байцаагчийн 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн баталсан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд урьдчилсан үзлэг зохион байгуулах тухай" удирдамж, хуваарийн дагуу Хяналт шалгалтын газрын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдөр нийслэлийн Архивын газрын Төлөвлөлт, мэргэжлийн удирдлагын хэлтсийн Архивын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Ш.Түвшинтөгс, Төрийн архивын хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Сарантуяа нар хяналт шалгалтыг явуулж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.




Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах чиглэлээр Нийслэлийн Архивын газрын дарга бөгөөд Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын Улсын ахлах байцаагчийн 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 09/04 дугаар албан шаардлага ирүүлсэн. Уг албан шаардлагын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр газрын даргаар батлуулсан. Албан шаардлагын дагуу илэрсэн зөрчил, дутагдлыг арилгаж, биелэлтийг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 01/674 дугаар албан бичгээр Нийслэлийн Архивын газарт хүргүүлэв.

**Мэргэжил арга зүй, сургалтын талаар:** Байгууллагын албан хаагчдыг архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, баримт бичгийн стандарт болон баримт бичгийг зохион бүрдүүлэх арга зүйн талаар 5 удаа, монгол бичгийн ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр 2 удаагийн сургалт зохион байгуулав. Мөн Нийслэлийн Архивын газраас 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулсан улсын үзлэгийн дүгнэх үзүүлэлт, аргачлалын дагуу нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдад мэргэшил арга зүйн заавар, зөвлөгөө өгөх сургалтад 3 албан хаагч хамрагдав.




**Бэлтгэл, зохион байгуулалтын хүрээнд:** Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт бэлтгэх ажлын хүрээнд ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2025 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр хуралдаж, бэлтгэл арга хэмжээний төлөвлөгөө болон хийх ажлын хуваарийг хэлэлцэн баталсан.



**Санхүүжилт, зардлыг шийдвэрлэх хүрээнд:** Улсын үзлэгийн бэлтгэл ажлын хүрээнд 2025 онд нийт 7.790.940 төгрөгийг архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаагаа сайжруулахад зарцуулсан байна.

Д/д	Хөрөнгийн нэр	Тоо хэмжээ
1	Галын булан	1
2	Анхны тусламжийн хайрцаг	1
3	Галын булангийн хаяг	1
4	Аранз	1
5	Галын дохиолол, камер	1
6	Чийг дулаан хэмжигч	1
7	Аваарын түлхүүрийн хайрцаг	1
8	Уртасгагч залгуур	2
9	Архивын шүүгээний засвар	1
10	Баримтын тоос сорогч	1
11	Архивын баримтын хамгаалалтын хайрцаг	350
12	Архивын бор хавтас	800
13	Утас далдлагч (шалны)	15
14	Утас далдлагч (ханын)	20
15	Халаад (1 удаагийн)	12
16	Анхны тусламжийн эм	1
17	Аюулгүй ажиллагааны зааварчилгааны дэвтэр	2
18	Анхан шатны зааварчилгааны дэвтэр	2
19	Баримт бичиг зохион бүрдүүлэх гарын авлага хэвлүүлэх зардал (16 төрөл)	800
20	Вирусийн программ	1



**Архивын баримтад тооллого явуулах хүрээнд:** Нийслэлийн Архивын газрын дарга бөгөөд Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын Улсын ахлах байцаагчийн 2025 оны “Зөрчил арилгуулах тухай” 09/04 дүгээр албан шаардлагын хэрэгжилтийг хангах, хадгаламжийн нэгжийн бодит тоог тогтоох, тоо бүртгэлтэй тулгах, механик болон биологийн гэмтлээс урьдчилан сэргийлэх, сэлбэн засах шаардлагатай баримтыг илрүүлэх зорилгоор Хяналт шалгалтын газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/44 дугаар тушаалаар байгууллагын архивын сангийн баримтын тооллого зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулж, тооллого хийх удирдамж, хуваарийг баталсан. Байгууллагын архивын сангийн 2020-2023 оны баримтад тооллого хийх ажлыг 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс 06 дугаар сарын 20-ны өдрийг дуустал хугацаанд зохион байгуулав.



Тооллогын дүнг дараах хүснэгтэд үзүүлэв. Үүнд:

Д/д	Үзүүлэлт	Хадгаламжийн нэгж (тоо)
1	Данс, бүртгэлээр	1167
2	Дутагдаж буй	0
3	Алгассан дугаар бүхий	62
4	Давхардсан дугаар бүхий	55
5	Буруу байрлуулсан	49
6	Өөр хөмрөг, архивд шилжүүлбэл зохих	0
7	Данс, бүртгэлд ороогүй	3

8	Хөгц болон хорхой шавжид идэгдсэн	0
9	Тооллого шалгалтад хамрагдсан	1167
10	Ариутгах шаардлагатай	0
11	Сэлбэн засах шаардлагатай	22
12	Үдэж хавтаслах шаардлагатай	354
13	Бичвэр тодруулах шаардлагатай	0
14	Сэлбэн засах боломжгүй гэмтсэн	0
15	Техник боловсруулалт хийх шаардлагатай	49
16	Түр ашиглуулахаар олгосон	0

**Баримтыг эмхлэн цэгцлэх хүрээнд:** Тавиурт байрлуулсан түр хадгалах баримтыг дахин шалгаж, нүүр бичилт болон задалж засварлах ажлыг хийж гүйцэтгэн, хайрцагласан баримтыг бүртгэлтэй тулгалт хийж, баримтын “Байршлын заагуур”-ыг байрлуулсан.



**Дүгнэх үзүүлэлт тус бүрээр танилцуулга, холбогдох баримт бичгийг бэлтгэх хүрээнд:** Ажлын хэсгийн бүрэлдэхүүн 3 үндсэн үзүүлэлт, 87 шалгуур үзүүлэлт тус бүрээр 2020-2024 оны баримтыг шүүж, цаасан болон цахим баримтыг бүрдүүлсэн.



Мөн байгууллагын дотоод сүлжээ буюу баримт бичгийн цахим хавтас SHARED FOLDER (Y)-д 2020-2024 оны архив, албан хэрэг, байгууллагын ажлын зохион байгуулалттай холбоотой файлуудыг чиглэл тус бүрээр ангилан байршуулж, лавлах зориулалтаар ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн.



... > Архивын үзлэгийн файлууд 2020-2024 > Газрын дүрэм.

> This PC > SHARED FOLDER (Y:) > \_\_\_\_Архивын үзлэгийн файлууд 2020-2024


Name	Date modified
____Газрын дүрэм, журам, төлөвлөгөө ЛАВЛАХ ФАЙЛ	10/15/2025
1. АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	10/15/2025
2. БАЙГУУЛЛАГЫН АРХИВЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	10/12/2025
3. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	10/14/2025
Ажлын хэсгийн материал	1/4/2026
Гарын авлага	12/29/2025
Улсын үзлэг - Тогтоол, захирамж, аргачлал	9/24/2025
Хууль, эрх зүй	1/4/2026

Name	Date modified
ERP систем ашиглалт	10/15/2025 10:36 AM
Арга зүй, гарын авлагууд	11/13/2025 11:26 AM
Архив, албан хэрэг, журам 2019, 2022, 2024	10/14/2025 11:45 PM
АТТ 2020, 2022, 2023	10/15/2025 12:21 AM
Бичиг хэрэг, архивын ажилтны АТТ	10/15/2025 12:09 AM
Бичиг хэрэг, архивын ажилтны эд хөрөнгө, ХАБ	10/15/2025 12:22 AM
БНШК тушаал, дүрэм	10/15/2025 10:57 AM
Газрын албан тушаал, ангилал зэрэглэл 2020-2025	11/13/2025 11:26 AM
Газрын төлөвлөгөөнүүд 2020-2025	10/14/2025 10:54 PM
Газрын үйл ажиллагаа тайлан 2020-2023	10/15/2025 1:28 PM
Дотоод сүлжээ, мэдээлэл технологи	10/15/2025 12:05 AM
Дотоод хяналт - журам, тайлан 2022-2025	10/14/2025 11:58 PM
Индекс баталсан тушаал 2019-2025	10/14/2025 11:26 AM
Стратеги төлөвлөгөө	10/14/2025 8:12 AM
Сургалт, нийгмийн баталгаа	10/24/2025 9:13 AM
Тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас тушаал 2019-2025	10/15/2025 12:26 AM
Хөдөлмөрийн дотоод журам 2020-2025	10/14/2025 10:50 PM
ХӨНЖК 2025 он	9/19/2025 10:46 AM
Хэлтсүүд дүрэм, чиг үүрэг 2020-2024	10/14/2025 11:51 PM

**Улсын үзлэгт бэлтгэх ажлын хүрээнд өрөө, тасалгаа болон техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах хүрээнд:** Архивын өрөөг стандарт, шаардлагад нийцүүлэн бүрэн бэлтгэсэн. Мөн байгууллагын сургалтын танхимд улсын үзлэгийн комиссын гишүүдэд зориулсан компьютерыг бэлтгэн дотоод сүлжээнд нэвтрэх эрхийг тохируулж, принтер, сканерыг холбон ашиглахад бэлэн болгосон.



**Ном, гарын авлагаар хангах хүрээнд:** Байгууллагын үйл ажиллагаанд боловсруулагдаж буй баримт бичгийг MNS 5140-1:2021 “Баримт бичгийн нэр, төрөл, тодорхойлолт”, MNS 5140-2:2021 “Баримт бичгийн бүрдэл, тэдгээрт тавих шаардлага”-ын дагуу боловсруулах аргачлалын талаар албан хаагчдын өдөр тутмын хэрэглээнд зориулсан нийт 16 төрөл (эх бэлтгэлийг хавсралтаар оруулав)-ийн гарын авлагыг бэлтгэн, хүргүүллээ.



**Улсын үзлэгийн явц, үр дүн:** Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1220 дугаар захирамжаар баталсан хуваарийн дагуу Нийслэлийн Архивын газрын дарга, Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын Улсын ахлах байцаагч А.Гантулгаар ахлуулсан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Захиргааны бодлого, төлөвлөлтийн тасгийн дарга О.Мөнхтуяа, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Эрх зүйн бодлого, зохицуулалтын хэлтсийн Ахлах мэргэжилтэн Б.Ууганжаргал, Нийслэлийн Архивын газрын Төлөвлөлт, мэргэжлийн удирдлагын хэлтсийн дарга, Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын Улсын байцаагч Р.Саранцэцэг, Нийслэлийн Архивын газрын Төлөвлөлт, мэргэжлийн удирдлагын хэлтсийн сургалт хариуцсан мэргэжилтэн Б.Наранцацрал нарын бүрэлдэхүүнтэй Ажлын хэсэг 2025 оны 10 дугаар сарын 15-аас 16-ны өдрүүдэд төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгийг зохион байгуулж, үнэлгээ, дүгнэлт өглөө.

Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгийн дүгнэх үзүүлэлт, шалгуур тус бүрийн дагуу бэлтгэсэн холбогдох баримт бичиг, танилцуулга, нотлох материалыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд танилцуулж, хүргүүлэн ажиллав. Мөн тус газарт 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр улсын хэмжээний төв комиссын бүрэлдэхүүн ажиллаж, өмнөх үнэлгээг ахиулан бататгалаа.





Нийслэлийн Хяналт шалгалтын газар нь төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт нэгдсэн дүнгээр 95 хувийн үнэлгээ авч, нийслэлийн Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А/1819 дүгээр захирамжаар нийслэлийн хэмжээнд шилдэг байгууллагаар шалгарч **“Батламж”** гардан авлаа.



**3.10.2. Хариутай болон хариугүй албан бичгийн шийдвэрлэлт:** Байгууллагын хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 4521 албан бичиг ирж, үүнээс шийдвэрлэсэн 4175, судалж буй 346 албан бичиг байна. Бичгийн шийдвэрлэлт 92.3 хувийн үзүүлэлттэй байна.

Гадагшаа төрийн байгууллага болон аж ахуй нэгж байгууллага, иргэнд нийт 1263 албан бичиг илгээсэн байна. Гадагш явсан бичгийг хэвлэмэл хуудсанд буулган байгууллагын архивд үлдэх хувийг үйлдэн газрын даргын гарын үсэг, тамгаар баталгаажуулан ажиллав.

Д/д	Хэлтэс	Нийт ирсэн	Хариутай	Хариугүй	Судлагдаж байгаа	Хугацаандаа шийдвэрлэсэн	Шийдвэрлэлтийн хувь
1	Захиргаа, санхүүгийн хэлтэс	429	122	307	13	416	97,9%
2	Дотоод хяналт, шинжилгээний хэлтэс	36	8	28	2	34	95%
3	Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтэс	962	193	769	23	939	99,7%
4	Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс	2213	240	1973	139	2074	99,2%
5	Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтэс	638	68	570	37	601	98,6%
6	Орчны аюулгүй байдлын хяналтын хэлтэс	113	13	100	2	111	100%

### Эрх зүйн баримт бичигт дугаар олголт

Д/д	Эрхзүйн баримт бичиг	2023 он	2024 он	2025 он
1	Акт	10	5	-
2	Албан шаардлага	313	117	587
3	Дүгнэлт	273	111	507
4	Зөвлөмж	187	16	83
5	Удирдамж	28	2	30

### 3.11. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт


Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1049 дүгээр журмаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ын дагуу байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийг түргэн шуурхай хуулийн үндэслэлтэй судлан шийдвэрлэх, шийдвэрлэлтийн явцад зөрчил үүсгэхгүй байх талаар албан хаагчдад тогтмол мэдээлэл өгч, хяналт тавин ажиллаж байна.

2025 оны жилийн эцсийн байдлаар байгууллагын хэмжээнд нийт 3044 өргөдлийг хүлээн авч, хугацаандаа шийдвэрлэсэн 2957 буюу 97.14 хувь, шийдвэрлэх шатандаа байгаа 76 буюу 2.50 хувь, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 11 буюу 0.36 хувь байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа нь 18 хоног 19 цаг 57 минут байна.

Өргөдөл, гомдлын тоон үзүүлэлт:



Өргөдөл, гомдлын төрөл:




Бүртгэгдэж ирсэн өргөдлийн 64.03 хувь нь гомдол байна.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал:



## Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх явцад гарсан зөрчил:



2024 онд 477 зөрчил бүртгэгдсэн бол 2025 онд 199 зөрчил бүртгэгдэж, зөрчлийн тоо 61.0 хувиар буурсан байна.

Мөн чиг үүрэгт хамааралгүй өргөдөл, гомдол шилжүүлэх асуудлаар НҮНТ-ийн өргөдөл, гомдлын ажилтан болон 7 төвийн үйлчилгээний оператор, мэдээллийн ажилтнуудаас бүрдсэн 30 гаруй хүнийг хамруулсан цахим уулзалтыг 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулж, барилга, дэд бүтцийн салбарын чиг үүрэг, өргөдөл гомдлыг оновчтой хуваарилах талаар мэдээлэл солилцсон.



### 3.12. Ажилтан, албан хаагчдын ажлын сахилга хариуцлага, байгууллагын соёл, дэг журмыг сахиулах, ажлын бүтээмжийг дээшлүүлсэн байдал, үр дүн

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр (2024-2030 он)”-ийг хэрэгжүүлэх зорилгоор Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 2 зорилтын 8 арга хэмжээг төлөвлөж тайлант хугацаанд хэрэгжилтийг ханган ажиллав. Үүнд:

- Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн 3 гомдол, мэдээллийг хуулийн хугацаанд шийдвэрлэн, “Ёс зүйн дэд хороо”-ны 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 01 дугаартай дүгнэлтийг албажуулж, газрын удирдлагад хүргүүлж ажиллав.
- “Төрийн албан хаагчийн ёс зүй ба авлигын гэмт хэрэг” сургалтыг 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулав.
- Байгууллагын албан хаагчдын ёс зүй, зан харилцааны талаар санал асуулга явуулж, шалгуур үзүүлэлтийг үндэслэн албан хаагчийг тодруулж, газрын удирдлагад 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдөр танилцуулав.
- Нийслэлийн Хүний нөөцийн сургалтын төвийн багш Ш. Жаргалсайхан “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалтыг 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулав.
- Байгууллагын Ёс зүйн дэд хорооны төлөвлөгөөнд тусгагдсан “Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх сарын аян”-ы хүрээнд зохион байгуулагдах “Стресс ба ажлын байран дахь харилцаа”, “Удирдах ажилтны ёс зүйт манлайлал” сэдэвт сургалтыг 2025 оны 10 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан.
- Сэтгэлзүйч багш Б.Баярмаатай хамтран албан хаагчдын сэтгэлзүйн эрүүл мэндийг дэмжих зорилгоор ганцаарчилсан уулзалт, зөвлөгөө өгөх үйлчилгээг зохион байгуулж, нийт 6 албан хаагчийг хамрууллаа.

- Ёс зүйн дэд хорооноос санаачлан зохион байгуулж буй "Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх аян"-ы хүрээнд нийт албан хаагчдыг соён гэгээрүүлэх, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, урам зориг өгөх зорилгоор "Талархлын самбар"-ыг байршууллаа. Мөн тус аяны хүрээнд шилжин явах дарцгийг хэлтсүүдээр аялуулж, үлгэр жишээ хэлтсийг шалгаруулахаар ажиллаж байна.



### 3.13. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Монгол Улсын Авлигын эсрэг хууль, Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр, холбогдох эрх зүйн актын хэрэгжилтийг хангах зорилгоор 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр "Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө"-г баталж, нийт 3 зорилт, 15 арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх "Авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөө"-ний хагас жилийн хэрэгжилт, тайлан мэдээг нэгтгэн боловсруулж, 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 01/575 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэв.

Түүнчлэн "Эрх зүйн актад тавих хяналтыг сайжруулах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай" газрын даргын чиглэлийг боловсруулж, 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр батлуулав.

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд дараах 2 удаагийн сургалт болон сурталчлан таниулах ажлыг зохион байгуулав. Үүнд:

- Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйлд заасан "Нийтийн албан тушаалтан хахууль авах гэмт хэрэг"-т оногдуулах ялын хэмжээ нэмэгдсэнтэй холбогдуулан 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр "Төрийн албан хаагчийн ёс зүй ба авлигын гэмт хэрэг" сэдвээр нийт албан хаагчдад мэдээллийн цаг зохион байгуулсан.
- Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр "Авлигаас урьдчилан сэргийлэх

нь: Анхаарах асуудал” сэдвээр нийт албан хаагчдад мэдээллийн цаг зохион байгуулсан.





Байгууллагын онцлогт тохирсон дараах хэвлэмэл хуудас, сурталчилгааны материалыг мэдээллийн самбар, вэб сайт, пэйж хуудас зэрэгт байршуулан иргэд, олон нийтэд авлигын эсрэг үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг тогтмол хүргэж ажиллав. “Бод, нягтал, тэгээд татгалз” уриатай зурагт хуудас, сурталчилгааны материал - 50 ширхэг, “Шударга ёс, хөгжил дэвшилд хүргэх 110” мэдээллийн хэвлэмэл хуудас - 50 ширхгийг тус тус тараасан байна

Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын 48 мэдүүлгийг албан хаагчдаар мэдүүлэн, хяналт тавин ажиллав. Шинээр томилогдох, албан үүрэг хавсран гүйцэтгэх, болон шилжин ажиллахаар нэр дэвшсэн нийт 24 албан хаагчийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хүлээн авч баталгаажуулан, холбогдох материалыг бүрдүүлэн Авлигатай тэмцэх газрын Дүн шинжилгээ хяналт, шалгалтын хэлтсээр хянуулав.

## ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ


### 4.1. Байгууллагын ил тод байдлыг хангах чиглэлээр хийж хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолоор “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ын хэрэгжилтийг хангуулах зорилгоор албан ёсны цахим хуудас [www.inspection.ub.gov.mn](http://www.inspection.ub.gov.mn), пэйж хуудас “Нийслэлийн Хяналт шалгалтын газар”, мөн мэдээллийн самбараар дамжуулан байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хүний нөөцийн мэдээлэл болон үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн мэдээ, мэдээллийг иргэд, олон нийтэд тогтмол нээлттэй хүргэн ажиллаж байна.




Байгууллагын вэб хуудасны хэвийн үйл ажиллагааг хангах, шинэчлэх, мэдээллийн үнэн зөв байдлыг хангах үүднээс дараах хөгжүүлэлтүүдийг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- “Мэдээ, мэдээлэл” хэсэгт 21 удаа мэдээ оруулж, бусад мэдээ мэдээллийг засварлав.
- “Ил тод байдал” хэсгийн Хүний нөөцийн ил тод байдал, Үйл ажиллагааны ил тод байдал, Төсөв, санхүүгийн ил тод байдал, Бусад мэдээллийн ил тод байдал хэсэг тус бүрээр холбогдох мэдээллийг оруулж, харуулах хэсгийг шинээр хөгжүүлсэн.
- Хүний нөөцийн ил тод байдал хэсэгт Төрийн жинхэнэ албан хаагчдын гүйцэтгэлийн тайлан, үнэлгээ функцийг шинээр хөгжүүлсэн.
- Шил ажиллагааны хүрээнд вэб сайтад Дэлгэрэнгүй мэдээлэл авах эх сурвалж функцийг шинээр хөгжүүлсэн.
- Үйл ажиллагааны ил тод байдал хэсэгт албан хаагчдын мэдээлэл, албаны цахим шуудангийн хаягийг байршуулж, тогтмол шинэчилсэн.
- Бусад мэдээллийн ил тод байдал хэсэгт Ёс зүйн дэд хороотой холбоотой шинэ хуудас хөгжүүлж, мэдээллийг байршуулсан.
- Байгууллагын цахим хуудас Inspection.ub.gov.mn-ийн Админ удирдлага хэсгийн хөгжүүлэлтийг хийж, 90 хувьд хүргэв.





Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангуулах хүрээнд Нийтийн мэдээллийн (shilen.gov.mn) цахим системд мэдээлэл хариуцагч байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ зэрэг 5 бүлэг 87 үзүүлэлтээр улирал бүрийн тайланг бөглөж, хугацаанд нь илгээсэн. “Шилэн индекс”-ийн 2025 оны 02 дугаар улирлын тайланг 06 дугаар сарын 30-ны өдөр илгээж 76.64 хувь, 2025 оны 03 дугаар улирлын тайланг 09 дүгээр сарын 30-ны өдөр илгээж 99.15 хувиар тус тус үнэлэгдэв.



**Хэвлэл мэдээллийн чиглэлээр:** Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэстэй хамтран ажиллах 7 удаагийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хотын өнгө үзэмжийг сайжруулах, иргэдийн эрүүл, аюулгүй, ая тухтай орчинд амьдрах эрхийг хангах зорилгоор нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн зам, талбайн зөрчлийг арилгах, засвар, тохижилт, шинэчлэлтийн ажлын явцад хяналт шалгалт хийж буй талаар 107 мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэн ажиллалаа. Тус мэдээ, мэдээллийг Ulaanbaatar.mn “Улаанбаатар мэдээ”, Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Inspection.ub.gov.mn цахим хуудас болон албан ёсны пэйж хуудсаар нийтэлсэн бөгөөд бусад мэдээллийн хэрэгсэл болох gogo.mn, ikon.mn, dorgio.mn, newswire.mn, 24 цаг мэдээ.мн, UBS TV, Eagle TV зэрэг мэдээллийн хэрэгслээр нийтлэгдэж, 19,401 хүн үзсэн байна. Үүний дотор 525 хүн мэдээг хуваалцаж, 524 хүн сэтгэгдэл бичсэн байна.

№	Хэвлэл мэдээллийн байгууллагын нэр		Төрөл	Тоо	Тоо			
					Таалагдсан	Үзсэн	Хуваалцсан	Сэтгэгдэл
1	Улаанбаатар мэдээ		мэдээ	36	1285	1064	263	142
			live	16	996	80900	109	367
2	Хяналт шалгалтын газар	Вэб сайт	мэдээ	11	227	44	92	11
			мэдээ	43	38	-	1	2
		Facebook	live	16	119	4763	60	1
			мэдээ	1	-	-	-	-
3	Ulaanbaatar.mn		мэдээ	32	1	-	-	-
4	UB ERP систем		мэдээ	1	-	14	-	-
5	Eagle news		live	1	25	4300	-	1
6	GoGo.mn		мэдээ	3	-	-	-	-
7	UBS TV		мэдээ	2	-	-	-	-
8	Thahur.mn		мэдээ	2	-	-	-	-
9	News.mn		мэдээ	2	-	-	-	-
10	Dorgoi.mn		мэдээ	2	-	-	-	-
11	Ikon.mn		мэдээ	2	-	-	-	-
12	Товч.МН		мэдээ	2	-	-	-	-
13	Сүхбаатар дүүрэг		мэдээ	1	33	-	15	-
14	Хан-уул дүүрэг		live	1	31	-	18	1
<b>Нийт:</b>				<b>170</b>	<b>2755</b>	<b>91085</b>	<b>525</b>	<b>524</b>



Нийслэлийн Хяналт шалгалтын газрын үйл ажиллагааг иргэд олон нийтэд таниулан сурталчлах, түгээх зорилгоор “Пауэр медиа продакшн” ХХК-тай 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр хамтран ажиллах гэрээ байгуулан 8 минутын контент, 90 секундын рийл хийлгэн цахим сүлжээнд байршуулсан.



#### 4.2.Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангасан байдал буюу шилэн дансны хөтлөлтийн байдал, үр дүн

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд байгууллагын үйл ажиллагаа, төсөв санхүү, хүний нөөцтэй холбоотой мэдээллийг <https://shilendans.gov.mn/> цахим системд хуульд заасан хугацаанд тухай бүр байршуулж, олон нийтэд нээлттэй мэдээлэн, төсөв, санхүүгийн ил тод байдлыг ханган ажиллаж байна. Тайлант хугацаанд Шилэн дансанд байршуулах нийт 171 мэдээллээс 149 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан бөгөөд 5 мэдээллийг хугацаа хоцорч байршуулсан, хугацаа болоогүй 17 мэдээлэл байна.

**ШИЛЭН ДАНС** | Нийслэлийн Хяналт шалгалтын газар

И-мэйл: shilendans@ud.gov.mn | Ажлын утас: 70118030

Шуудангийн хаяг: Нийслэлийн Хяналт шалгалтын газар


Далгарангүй мэдээлэл: Санбар байгууллагуул

Тайлант он: 2025 | Нийт хэмжээ: 936 | Тэмдэглэгээний тайлбар

Төсвийн Байгууллага

Төсөв, гүйцэтгэл | Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт | Бусад

№	Тайлангийн нэр	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах хугацаа	Зөвөлжсөн эсэх	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл - Кетибер, хэрэгжлэлт	дараа сарын Ө-нэ дотор		✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
2	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, зөвхөн санхүүгийн мэдээллийг тайлбарны хяналт, эдийн засгийн зүгнэлэл	дараа сарын Ө-нэ дотор		✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓



## ТАВ. БУСАД МЭДЭЭЛЭЛ

### 5.1. Олон нийтийн арга хэмжээ

✚ Нийслэлийн Аялал жуулчлалын газар, “Скай резорт” ХХК-тай хамтран “Улаанбаатарын өвлийн наадам” арга хэмжээг 2025 оны 02 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд “Скай резорт” цанын баазад зохион байгуулагдаж, тус газрын 2 албан хаагч бүжгийн тэмцээнд амжилттай оролцлоо.



✚ “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжиж буй “Ногоон хот-Иргэний оролцоо” хаврын мод тарих, арчлах арга хэмжээний хүрээнд Нийслэлийн Хяналт шалгалтын газрын хамт олон 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Баянзүрх дүүргийн 28 дугаар хороо, IGM-Олон улсын эко цэцэрлэгт хүрээлэнгийн төслийн талбайд 5 ширхэг монос, 15 ширхэг агч мод тарьж, байгаль орчны нөхөн сэргээлт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажилд хувь нэмрээ орууллаа.




✚ Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, 340 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх хүрээнд улс, орон даяар зохион байгуулагдсан газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн дадлага, сургуулилтад 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 16:00 цагт зарлан мэдээллийн дуут дохиогоор нийт 43 албан хаагч хамрагдлаа. Дадлага, сургуулилын үеэр “Суу-Нуугд-Хүлээ” зарчим, гадагш нүүлгэн шилжихдээ “Гүйхгүй-Ярихгүй-Түлхэхгүй-Эргэж буцахгүй” зарчмыг мөрдөн, газар хөдлөлт, галын аюулд өртсөн барилга, объектоос


гамшгийн үед ашиглах гарцаар гарч, тогтоосон цугларах цэгт цуглах дадлагыг зохион байгууллаа.



✚ Нийслэлийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн “Хог хаягдал, орчны бохирдлыг бууруулах зарим арга хэмжээний тухай” А/354 дүгээр захирамжийн дагуу 90 минут бүх нийтийн их цэвэрлэгээнд 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр оролцож, Нийслэл хүрээ өргөн чөлөө, Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгээс 120 мянгатын тэмээтэй уулзвар хүртэл явган хүний замын дэргэдэх түүвэр хог хаягдлыг цэвэрлэсэн.




✚ Монгол Улсад гүйлтийн спортыг хөгжүүлэх, гүйлтээр хичээллэгч, сонирхогч иргэдийн тоог нэмэгдүүлэх, өсвөр, залуу үеийнхэнд бие бялдар, оюун санааны өв тэгш хүмүүжлийг төлөвшүүлэх зорилготой “Улаанбаатар марафон 2025” олон улсын гүйлтийн тэмцээн 2025 оны 05 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулагдаж, тус газрын албан хаагчид амжилттай оролцлоо.



## 5.2. Оны онцлох үйл явдлууд

### 1) “Нийслэлийн Хяналт шалгалтын газрын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө” батлагдлаа.

Монгол Улсын Үндсэн хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал, загвар”-ын дагуу “Хяналт шалгалтын газрын 2025-2028 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө”-г боловсруулан Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатараар батлууллаа. Хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд 3 зорилго, 10 зорилт арга хэмжээг тусгасан.



### 2) “Барилга, дэд бүтцийн салбарын хяналт шалгалтын тогтолцоо” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулав.

Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 03 дугаар тогтоолоор батлагдсан ажлын хэсгийн 01 дүгээр хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр “Барилга, дэд бүтцийн салбарын хяналт шалгалтын тогтолцоо” сэдэвт хэлэлцүүлгийг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Авлигатай тэмцэх газар, Хяналт шалгалтын газар, Хот байгуулалт, хотын стандартын газартай хамтран зохион байгууллаа.

Тус хэлэлцүүлэг нь барилга, дэд бүтцийн салбарын хууль тогтоомж, норм, дүрэм, стандартын хэрэгжилт, ажлын гүйцэтгэлд тавих хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, төрийн байгууллагаас олгодог барилгын үе шатны зөвшөөрөл, тэдгээрийн дараалал, хугацаа, хяналтын давхардлыг бууруулах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх нөхцөлийг бүрдүүлэх, салбарт тулгамдаж буй асуудлыг хэлэлцэн, хэлэлцүүлгээс гарсан санал, дүгнэлтийг нэгтгэн холбогдох байгууллагад санал, зөвлөмж хүргүүлэх зорилготойгоор зохион байгуулагдсан.

Хэлэлцүүлгийг дараах 3 салбар хуралдааны хүрээнд зэрэг зохион байгуулсан. Үүнд:  
- Салбар хуралдаан 1: “Барилга, дэд бүтцийн зураг төсөл боловсруулах үе шат”

- Салбар хуралдаан 2: “Барилгын угсралтын үйл ажиллагааны үе шат, хяналтын оролцоо”
- Салбар хуралдаан 3: “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах үйл ажиллагаа, түүнд тавих хяналт”



Хэлэлцүүлгийн явцад барилга, дэд бүтцийн салбарын хяналт шалгалтын тогтолцоонд тулгамдаж буй асуудал, хууль эрх зүйн орчны уялдаа холбоо, зөвшөөрөл олголт, хяналтын давхардал, ил тод байдал, авлигын эрсдэл зэргийг хөндөн ярилцаж, салбарын оролцогчдоос бодит санал, дүгнэлтүүдийг гаргав.

### 3) Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүн байгууллагуудын хамтарсан хэлэлцүүлэг зохион байгуулав.

Нийслэлийн хэмжээнд барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүн байгууллагуудтай мэдээлэл солилцох хамтарсан уулзалт, хэлэлцүүлгийг Нийслэлийн Хяналт шалгалтын газраас 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгууллаа. Тус хэлэлцүүлэгт барилга байгууламжийн инженерийн хангамж, галын аюулгүй байдал, барилгын үндсэн хийц бүтээц, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашиг хангагдсан эсэхэд үзлэг шалгалтын үйл ажиллагааг зохион байгуулдаг 11 байгууллагын 44 албан хаагчид оролцлоо. Хэлэлцүүлгээр Нийслэлийн Хяналт шалгалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Энхбаяр нийслэлийн хэмжээнд бага, дунд, өндөр төвөгшилтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг сайжруулах, авлига ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх зорилгоор зөвлөлдөж мөрдөгдөж байгаа эрх зүйн орчинг боловсронгуй болгох талаар хэлэлцүүлэг өрнүүллээ. Засгийн газрын 2021 оны 212 тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/503 дугаар захирамж, дүрмийг шинэчлэх тухай саналыг нэгтгэн боловсруулж зохион байгуулалт, эрх зүйн орчинг сайжруулах шийдвэрийн төслийг боловсруулж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.




Барилга байгууламжийг ашиглалтад оруулах үйл ажиллагааг боловсронгуй болгох, барилгын салбарт оролцогчдын хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-д санал тусгах, шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд уулзалт, хэлэлцүүлгийг 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдөр зохион байгууллаа.






#### 4) Байгууллагын үйл ажиллагаандаа хиймэл оюун ухаанд суурилсан цахим систем нэвтрүүлж эхлэв.

Байгууллагын цахим хөгжил, дижитал шилжилт, хиймэл оюун ухаан болон бусад дэвшилтэт технологи нэвтрүүлэхтэй холбоотой шинэ санал санаачилга дэвшүүлэх, бодлого төлөвлөлт боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулж, технологийн шийдлүүдийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагын дэргэдэх “Мэдээлэл технологийн хөгжлийн зөвлөл”-ийг байгуулсан.

Нийслэлийн нутаг дэвсгэр дээрх барилгажилтын үйл ажиллагааг ил тод, оновчтой хянах, зөвшөөрөлтэй ба зөвшөөрөлгүй барилгыг ялгах зорилгоор хиймэл дагуулын зураг болон хиймэл оюун ухааны загвар, шийдлүүдийг ашиглан зөвшөөрөлгүй барилгын ажлыг алсаас тандан илрүүлэх, хянах системийн судалгаа, туршилтын ажлыг эхлүүлсэн. Энэ чиглэлээр чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “И Ти Креатив” ХХК-тай 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдөр “Ажил гүйцэтгэх гэрээ”-г байгуулж, нийслэлийн хэмжээнд зөвшөөрөлгүй барилгажилт өрнөж буй талбайн координатыг таамаглах, газрын ашиглалт, хөрсний нөхцөл байдлын өөрчлөлтийг ажиглах аргачлалыг боловсруулан туршилтын шатанд бэлтгэл ажлыг хангаж байна.




Байгууллагын ажилтнуудын мэдээлэл хайх, албан бичиг боловсруулах, өдөр тутмын үйл ажиллагааг автоматжуулан хөнгөвчлөх зорилгоор RAG технологид суурилсан “Ажилтаны туслах” хиймэл оюун ухааны системийг хөгжүүлж байна.



## 5) Төрийн хяналт шалгалтын аппликейшн нэвтрүүлж эхлэв.

Төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг цахимжуулах, ил тод, үр дүнтэй болгох зорилгоор “UBInspection-Хяналт шалгалтын аппликейшн”-ийн гар утас болон вебд суурилсан программ хангамж хөгжүүлэх 24/10 дугаартай гэрээний хүрээнд сайжруулалтын ажлыг хийж, 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн нийт улсын байцаагчид тус аппликейшнийг хяналт шалгалтын үйл ажиллагаанд туршилтаар ашиглаж эхэлсэн. Хяналт шалгалтын ажлыг бүртгэлжүүлэх, мэдээллийн сан үүсгэх хүрээнд “UB Inspection” цахим бүртгэлийн системийг газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А/93 дугаар тушаалаар албан ёсоор төрийн хяналт шалгалтын үйл ажиллагаанд нэвтрүүлэв.



## ЗУРГАА. ДҮГНЭЛТ

Төрийн хяналт шалгалт болон барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор салбарын оролцогч талуудыг хамруулсан хэлэлцүүлэг, сургалтуудыг зохион байгуулж, холбогдох хууль тогтоомж, стандарт, норм, дүрмийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудлын талаар нэгдсэн ойлголт бүрдүүлэхэд анхааран ажиллалаа. Хууль тогтоомжийн хэрэгжилтэд тулгарч буй хүндрэл, зөрчлийг шийдвэрлэх хүрээнд холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, эрх бүхий байгууллагад хүргүүлсэн. Мөн төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, илэрсэн зөрчилд арга хэмжээ авч, биелэлтийг хангуулан ажилласан. Зөрчлийг арилгах үйл явцад мэргэжлийн зөвлөмж, арга зүйн дэмжлэг үзүүлж, байгууллага, аж ахуйн нэгжүүдийн хариуцлагыг нэмэгдүүлэхэд анхаарсан нь зөрчлийн тоо, эрсдэлийг бууруулахад эерэг үр дүн үзүүлэв.

Түүнчлэн байгууллагын үйл ажиллагааны ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх, хяналт шалгалтын процессыг шуурхай, оновчтой болгох зорилгоор цахим хяналтын систем нэвтрүүлэх чиглэлээр үе шаттай ажлуудыг эхлүүлж, мэдээллийн сан бүрдүүлэх, өгөгдөлд суурилсан хяналт шалгалт хэрэгжүүлэх суурийг тавин ажиллаж байна.

Нийслэлийн Хяналт шалгалтын газар нь 2025 онд төлөвлөгөөт зорилт, чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж амжилттай ажиллалаа. Тус газрын хагас жилийн гүйцэтгэлийг Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/905 дугаар захирамжаар “Бүрэн хангалттай” гэж үнэлсэн бол Нийслэлийн Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн “2025 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг дүгнэх тухай” А/1811 дүгээр захирамжаар жилийн эцсийн гүйцэтгэлийг мөн “Бүрэн хангалттай” гэж дүгнэсэн. Түүнчлэн төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт нэгдсэн дүнгээр 95 хувийн үнэлгээ авч, Нийслэлийн Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А/1819 дүгээр захирамжаар нийслэлийн хэмжээнд шилдэг байгууллагаар шалгарч, “Батламж” гардан авлаа.

## ДОЛОО. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, САНАЛ

### Захиргаа, дотоод хяналтын хүрээнд:

- Үндсэн чиг үүргийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавих тогтолцоог бүрдүүлж, хэвшүүлэх;
- Албан хаагчдын ажлын ачаалал, дотоод ажлын чиг үүргийн хуваарилалтыг оновчтой зохион байгуулах;
- Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах;
- Албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлыг үе шаттай зохион байгуулах.

### Хүний нөөцийн үйл ажиллагааны хүрээнд:

- Албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулах;
- Сул орон тоог нөхөх, сонгон шалгаруулалтыг зохион байгуулж хүний нөөцийг бүрдүүлэх;
- Албан хаагчид, улсын байцаагч нарыг дадлагажуулах, мэдлэг ур чадварыг сайжруулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

### Хяналт шалгалтын үр нөлөөг сайжруулах хүрээнд

- Нийслэлийн хэмжээнд цогц лаборатори байгуулах санхүүжилт шийдвэрлүүлэх;
- Хяналт шалгалтын цахим системийн хөгжүүлэлтийг хийж, үйл ажиллагааг жигдрүүлэх;
- Төрийн хяналтын зарим чиг үүргийг ТББ, мэргэжлийн холбоодоор туслан гүйцэтгүүлэх тогтолцоог бүрдүүлэх.
- Зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагаанд гарч буй нийтлэг зөрчил, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсэд дүн шинжилгээ хийж, зөрчлийг бууруулах ажлыг үе шаттай төлөвлөх;
- Улсын (ахлах) байцаагч нарын цалин хангамж, зэрэг дэв ахиулах, онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох;
- Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл гомдол, хүсэлтэд дүн шинжилгээ хийж, бууруулах арга хэмжээг авч ажиллан, орчны эрсдэлийг бууруулж ажиллах;


### Барилга байгууламжийг ашиглалтад оруулах чиг үүргийн хүрээнд

- Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийг шинэчлэх;
- Ашиглалтад орсон барилга байгууламжийн мэдээллийг олон нийтэд ил тод болгох.

ТАНИЛЦСАН:  
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
ГАЗРЫН ДАРГА

ХЯНАСАН:  
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:  
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ, ТАЙЛАН  
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



С.ЭНХБАЯР

Б.БАЙГАЛМАА

М.ГАЧМАА